МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА”

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **БГСТ-25/019**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Ч.Анар

Улаанбаатар хот
2025 он

УДИРТГАЛ

Судлах болсон хэрэгцээ, шаардлага:

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах явдал жил ирэх тусам өссөн нь геополитик, нийгэм, эдийн засгийн байдал, хөгжил, дэд бүтэц, хяналт шалгалт, эрх зүйн орчин, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар, сэтгэхүй, төлөвшил, гадаад орны зарим иргэдийн сөрөг нөлөөллөөс шалтгаалж байна.

Монгол Улсын хэмжээнд өсвөр үе, залуучуудын архи, тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус хэрэглээ нь хэвлэл, мэдээллийн чөлөөт байдал, интернэтийн дэвшилтэт техник, технологи нэвтэрсэнтэй холбоотой бөгөөд үндэсний аюулгүй байдлын хэмжээнд аюул заналхийллыг хэдийнээ бий болгожээ.

Судлагдсан байдал:

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээрх судалгаанууд үндэсний хэмжээнд хангалттай түвшинд хийгдсэн байгаа боловч тодорхой нутаг дэвсгэр онцолж хийсэн судалгаа хийгдээгүй байна.

Энэ чиглэлийн судалгаануудаас дурдвал, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгээс гүйцэтгэсэн “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал” судалгааны ажлын тайлан 2016 он, НҮБ-ын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх хорооноос гаргасан “Дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын 2023, 2024 оны тайлан”, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойд зориулан 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт үндэсний эрдэм шинжилгээний хурлын хэлэлцүүлэг, эмхэтгэл зэргийг дурдаж болох юм.

Судалгааны ажлын хамрах хүрээ:

Судалгааны цар хүрээг Улаанбаатар хотын Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр гэж тодорхойлж, судалгааг явуулсан. Учир нь Чингэлтэй, Хан-Уул дүүргийн тухайд төвийн, хөл хөдөлгөөн ихтэй, мөн сургалтын төлбөр өндөр сургуулиуд байрладаг зэрэг нөхцөл байдлыг харгалзсан болно.

Судалгааны зорилго:

Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх өсвөр үеийн хүүхэд, залуучуудын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх ойлголтыг тодорхойлж, мансуурах хам шинжид өртөмтгий байдалд дүн шинжилгээ хийх замаар урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилт:

Судалгааны зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Мансуурах хам шинж, өнөөгийн нөхцөл байдлыг судлах,
2. Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх өсвөр үе, залуучуудын мансуурлын талаарх ойлголт, дүн шинжилгээ хийх,
3. Мансуурал ба өсвөр үеийн хамаарлыг тодорхойлох,
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх,
5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй эрх зүй зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ хийх,
6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй зохион байгуулалтыг судлах,
7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн статистикт дүн шинжилгээ хийх,
8. Прокурорын байгууллагын тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх,
9. Шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдэд дүн шинжилгээ хийх,
10. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс хүүхэд, өсвөр үеийг хамгаалах арга зам, шийдэл боловсруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй:

Судалгааны объектын онцлогтой холбоотойгоор өргөн сонголттой судалгааны арга хэрэглэсэн. Тухайлбал, анкетын асуулга, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага, тохиолдол шинжлэх, эрх зүйн баримт бичиг дүн шинжилгээ хийх, харьцуулах, орчны болоод цахим орчин дах контент шинжилгээ зэрэг судалгааны арга хэрэглэж үр дүнг бий боловсруулсан.

Ярилцлагын ганцаарчилсан хэлбэрээр цагдаагийн байгууллагын энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх чиг үүргийн алба хаагчидтай болон мансуурах хам шинжтэй хүмүүсийн хүрээнд явуулж, дүнг боловсруулсан.

НЭГ. МАНСУУРАХ ХАМ ШИНЖ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүн төрөлхтний нийгмийн сөрөг үзэгдлүүдийн дунд мансуурах дон нь хүний нөхөн үржихүйн үйл явц, хүн амын бие, физиологийн болон оюун санааны эрүүл мэндэд бодит аюул заналхийлэл учруулдаг төдийгүй Монгол Улсын хувьд "Үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, иргэдийн хэвийн амьдралд бодит бэрхшээл учруулж болзошгүй байна" гэж Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр[1]-т дурджээ.

Түүхийн эх сурвалжид "МЭӨ 5 мянган жилийн өмнө хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байсан нь булш бунхнаас олдсон эд зүйлсэд хадгалагдан үлдсэн"[2] бөгөөд нүүдлийн соёл иргэншилтэй манай улсын хувьд олсны төрлийн ургамлыг "Муу өвс" гэж нэрлэн, ургасан газрыг "бузартсан" гэж зарлаж, түүнийг идсэн мал, амьтан ухаан доройтон үхдэг гэж цээрлэж байсан бол XVIII зууны үеэс Хятад худалдаачид дэлгэрүүлж[3] эхэлсэн.

Монгол Улс тусгаар тогтнолоо олсны дараа хар тамхины аюулыг таслан зогсоохоор 1912 оны 06 дугаар сарын 27-нд Богд хааны зарлиг гарч, "*Хар тамхи хэмээгч бодис хамаг хортой бузар юм мөн хэмээх тул үүнээс урагш манай Монгол газарт тэрхүү хар тамхи хэмээгчийг элдэв хүн татаж хэрэглэх ба худалдааны пүүс, дотор газраас худалдан өгөх манай улсад тариандтарих явдлыг нэгэн адил чангалан цаазалсугай*"[4] гэж анх удаа хориглон, улмаар төрөлжсөн хууль тогтоомждоо хуульчлан иржээ. Гэсэн хэдий ч ардчилсан хувьсгал ялснаас хойш энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдсээр байна.

Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ нь зөвхөн хувь хүний эрүүл мэндийн асуудал төдийгүй, нийгмийн аюулгүй байдал, гэр бүлийн харилцаа, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон хүчин зүйлд сөргөөр нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэж, хүний эрүүл мэнд, сэтгэц, нийгмийн байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. 2023 оны байдлаар дэлхий даяар 296 сая хүн мансууруулах бодис хэрэглэсэн нь сүүлийн арван жилд 23%-иар өссөн үзүүлэлттэй байна[5]. Энэ үзүүлэлт цаашид ч эрчимтэй нэмэгдэх эрсдэлтэй байгааг олон улсын судалгааны байгууллагуудаас анхааруулсаар байдаг.

---

[1] Засгийн газрын 2000 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр

[2] Исаев, Игорь. В поисках забвения. Всемирная история наркотиков 1500—2000. — М.: ЭТП, 2003. — ISBN 5-9410-6029-7

[3] Мөнхболд, Ж. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа - 2. Уб., 2013. 3 дахь тал.

[4] Болдбаатар, Ж. Хар тамхи мансууруулах бодистой холбогдсон гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн шинж. Уб., 2001.4 дэх тал.

[5] "Online World Drug Report 2024 - Drug market patterns and trends." Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/wdr2024-drug-market-trends.html

Олон улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах төрлийн 141 төрлийн бодисуудыг Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”-оор зохицуулдаг бөгөөд Монгол Улсад мансууруулах 12, сэтгэцэд нөлөөт 29 төрлийн эмийг хүн амын эмчилгээнд, 65 төрлийн бодисыг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж байна[6].

Монгол Улс нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, эргэлттэй тэмцэх хууль эрх зүйн зохицуулалттай олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг улсуудын нэг бөгөөд 2023 оны байдлаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн тоо өмнөх оноос 27%-аар өссөн байна. Түүнчлэн эдгээр бодисыг хэрэглэх нас улам залуужиж, өсвөр насны хүүхдүүдийн дунд хэрэглээ нэмэгдэж буй нь тулгамдсан асуудал болоод байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэх орон байраар хангах, завших, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” үйлдлийг хуульчилж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[7], “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод[8] нийцүүлэн олон төрлийн ажил, арга хэмжээг үе шаттай зохион байгуулсаар байгаа ч үр дүнд хүрэхгүй, тухайн төрлийн гэмт хэргийн гаралт өсөж, тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Судалгааны үр дүнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь дан ганц хууль сахиулах байгууллагын дангаар гүйцэтгэх ажил биш бөгөөд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодсыг хууль зүй, анагаах ухаан, нийгмийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж, шалтгаан нөхцөлийг тогтоож, тэмцэх арга замыг тодорхойлж хэвшсэн байна. Тодруулбал, тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн чухал шалгуур нь хууль зүйн шалгуур буюу НҮБ-ын “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”-д багтсан бодис мөн эсэхийг тогтоох шаардлагатай. Тухайн төрлийн бодисыг ямар төрлийн бодис болохыг тогтоосноор гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлага, донтсон иргэнд үзүүлэх эмчилгээний тактикийг зөв сонгох, улмаар тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

---

[6] “Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://legalinfo.mn/mn/detail?lawId=206781

[7] Цус ойртолтыг багасгах, архидан согтууралд, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.

[8] Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал.

Шүүх шинжилгээний ерөнхий газар нь (ШШЕГ) 2000 оноос эхлэн мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх шинжилгээ хийж эхэлсэн бөгөөд одоогоор спирт, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, хорт бодис, угаарын хий зэрэг 7 төрлийн 30-аад нэр төрлийн бодис илрүүлэх шинжилгээг хийж байна.

Шүүх Шинжилгээний Ерөнхий Газарт 2024 оны байдлаар “Байгалийн ухаан шинжилгээний газар”-ын харьяа Химийн лабораторид нийт 8658 шинжилгээ хийгдсэн нь өмнөх 5 жилийн дунджаас 1147 нэгжээр өссөн бөгөөд нийт шинжилгээний 20-45%-ийг мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх шинжилгээ эзэлж байна.

Зураг 1. Сүүлийн 5 жилийн шинжилгээний тоон үзүүлэлт



Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх шинжилгээний 95%-ийг Эрүүгийн цагдаагийн алба, 5%-ийг бусад газруудаас ирүүлсэн байна.

Зураг 2. Улаанбаатар хотод хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлт



2024 оны байдлаар нийт мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх 1229 шинжилгээ хийснээс 87.8% (n=1080) нь Улаанбаатар хотод, 12.2% (n=149) нь орон нутгаас ирүүлсэн шинжилгээ байгаа бөгөөд тус онд хийсэн нийт шинжилгээг өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 2.2 дахин өссөн байна. 2024 онд нийслэлээс ирүүлсэн шинжилгээний 11.3% (n=122) Хан-Уул, 9.7% (n=105) Сүхбаатар дүүргээс ирүүлсэн шинжилгээ эзэлж байна.

Зураг 3. Орон нутагт хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлт



Түүнчлэн 2024 онд орон нутгаас ирүүлсэн шинжилгээг өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад мөн адил 2.2 дахин өссөн бөгөөд тус онд орон нутгаас ирүүлсэн нийт шинжилгээний 82.5% (n=123) төвийн бүс, 14.7% (n=22) хангайн бүсээс ирүүлсэн шинжилгээ эзэлж байна. Аймгаар нь авч үзвэл 50.3% (n=75) нь Дархан уул аймаг, 18.8% (n=28) нь Төв аймаг, 6.7% (n=10) нь Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээс ирүүлсэн шинжилгээ дийлэнх хувийг эзэлж байна.

Сүүлийн 4 жилийн хугацаанд ирсэн нийт сорьцоос мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх шинжилгээгээр ямар төрлийн бодис болохыг тогтооход 38.5% (n=1054) нь “Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-д ороогүй буюу МЕТ (метамфетамин) болон ТНС (тетрагидроканнабинол) тогтоогдсон бол 5.64 (n=154) нь ≥2 мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хамт илэрсэн ба үүний 77.2% (n=119) нь МЕТ, ТНС гэх хоёр бодис байсан. Түүнчлэн нийт сорьцын 1.3% (n=311) нь “Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-д орсон бодисууд байсан бол 2.16% (n=59) нь Габапентин-лактам (тебантин) гэх бодис тогтоогдсон.

Хүснэгт 1. Сорьцоос илэрсэн мансууруулах, сэтгэц нөлөөт бодис

№	**Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис**	**2021 он**	**2022 он**	**2023 он**	**2024 он**	**n; (%)**
		n; (%)				
1 төрлийн мансууруулах, сэтгэц нөлөөт бодис						
1	ADB-BUTINACA	-	1	3	9	
2	MDMA /экстази молли/	-	1	7	3	
3	MDMB-4en-PINACA /Пинака/	-	-	2	10	
4	Каннабидиол	1	2	-	-	
5	МЕТ /метамфетамин/	-	25 (0.9)	186 (6.8)	140 (5.1)	
6	ТНС	2	148 (5.4)	329 (12)	224 (8.2)	
7	Alpha-PVP /флакка/	-	1	-	2	
n; (%)		**1096 (40.1)**				**2732 (100)**
≥2 мансууруулах, сэтгэц нөлөөт бодис						

8	МЕТ, ТНС	-	5	59	55 (2)	
9	Бусад хослол	1	6	12	16 (0.6)	
n; (%)		154 **(5.64)**				
Эмчилгээнд хэрэглэх мансууруулах, сэтгэц нөлөөт бодис						
10	Морфин, диазепам, эфедрин, кодейн, альпразолам, трамадол, карбамазепин	5	10 (0.4)	9	7	
n; (%)		31 **(1.3)**				
Бусад						
11	**Габапентин-лактам /тебантин/**	1	16	8	34 (1.2)	
n; (%)		59 **(2.16)**				
12	Дээж хүрэхгүй буцаав	-		53 (1.9)	43 (1.5)	
13	Тодорхойгүй	39 (1.4)	123 (4.5)	449 (16.4)	680 (24.9)	
n; (%)		**723 (26.5)**				

Үүнээс гадна нийт шинжилгээний 3.5% (n=96) нь шаардлага хангахгүй (сорьц хүрэхгүй) буцаагдсан бол 47.3% (n=1291) сорьцод хязгаарлагдмал нөхцөл байдлын улмаас агуулагдаж буй бодисыг тогтоох боломжгүй байсан.

Зураг 4. Сорьцоос илэрсэн мансууруулах, сэтгэц нөлөөт бодис



Шүүх шинжилгээний ерөнхий газрын, Шүүх анагаах ухааны шинжилгээний газарт 2021-2025 оны хооронд эм, химийн бодис болон бусад зүйлээр хордож /ацетон, лак, моторын шингэн, хулган хор, цууны хүчил, ахуйн газ/ зэргийн улмаас нас барсан 82 тохиолдолд дүн шинжилгээ хийснээс 79.2% (n=65) нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой нас баралт байгаа бөгөөд үүний 23% (n=15) нь “Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-д орсон морфин, бензодиазепин-барбитуратын уламжлан эмүүд, 16.9% (n=11) нь дээрх жагсаалтад ороогүй мансууруулах, сэтгэц нөлөөт бодисууд /THC, MET, MDMA/ байсан бол үлдсэн 59.2% (n=37) нь ямар төрлийн бодис болохыг нь тогтоох боломжгүй байна.

Мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын донтолт, нас баралтад хийсэн дүн шинжилгээ.

Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис нь хүний бие махбод, сэтгэл санаа, нийгмийн харилцаанд ноцтой хор хөнөөлтэй бөгөөд хэрэглэсэн хүн донтох, сэтгэцийн эмгэгтэй болох, эрүүл мэндээрээ хохирох, улмаар гэр бүл, ажил, сургууль, нийгмийн амьдралд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд тухайн төрлийн бодсын байнгын хэрэглээ, хэт их тунгаар хэрэглэсний улмаас амьсгалын төвийг дарангуйлах, зүрх судас, уушги зэрэг амин чухал эрхтнүүдийг гэмтээж эргэшгүй өөрчлөлтөд оруулан үхэлд хүргэдэг байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2021-2024 оны байдлаар мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой нийт 336 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд нийт эмчлүүлэгсдийн 87.5% (n=294) нь Улаанбаатар хотоос, 22.5% (n=42) нь орон нутгуудаас ирсэн байна. Түүнчлэн 2024 онд хэвтэн эмчлүүлэгсдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 1.6 дахин их байна.

Хэвтэн эмчлүүлж буй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 36% (n=121) нь 20-24 нас, 20.2% (n=68) нь 25-29 нас, 16.3% (n=55) нь 15-19 насныхан эзэлж нийт эмчлүүлэгсдийн 83.6% (n=281) нь 15-39 насныхан эзэлж байна.

Зураг 7. СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгсдийн нас



Хүйсийн хувьд 64.58% (n=217) нь эрэгтэй, 35.42% (n=119) нь эмэгтэй байна. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн эмчлүүлэгчид өвчний олон улсын 10 дугаар ангилалд зааснаар /F11-F19/ оношоор хэвтэн эмчлүүлсэн бөгөөд 53.5% (n=180) нь F19 буюу “Олон төрлийн сэтгэц идэвхт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан төрхийн эмгэгүүд”, 12.5% (n=42) нь F12 буюу “Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгүүд” оноштойгоор хэвтэн эмчлүүлсэн байна.

Зураг 8. СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгсдийн онош



Нийт эмчлүүлэгчдийн 40% нь ажил эрхэлдэг, 16% нь оюутан байсан бол ажил эрхэлдэггүй хүмүүсийн эзлэх хувь нь 9.3% байна.

Зураг 9. СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгсдийн ажил эрхлэлт



Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног нь 2021 онд 18.7, 2022 онд 16.6, 2023 онд 16.5, 2024 онд 20.1 байгаа бөгөөд 2024 оны дундаж ор хоног өмнөх оноос 1.2 дахин ихэссэн байна.

Шүүх шинжилгээний байгууллага нь 2000 оноос эд мөрийн баримтаас мансууруулах, сэтгэц нөлөөт бодисыг илрүүлэх шинжилгээг хийж 2007 оноос шээсээр мансууруулах, сэтгэц нөлөөт бодис илрүүлэх шинжилгээ хийж эхэлсэн. Шинжилгээний цахим бүртгэлийн системд 2019 оноос мансууруулах бодис хэрэглэсэн болон хэрэглээд амь хохирсон тохиолдлыг бүртгэж эхэлсэн. 2019 оны байдлаар мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын улмаас амь хохирсон тохиолдол бүртгэгдээгүй.

Зураг 10. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын улмаас нас барсан тохиолдлын судалгаа



Сүүлийн 5 жилд 82 хүн хордлогын улмаас нас барсан бөгөөд үүнээс 21 нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний улмаас нас барсныг шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлтээр тогтоож, 33.8 хувийг нь ямар бодисын улмаас хордлогод орж нас барсныг тогтоогоогүй байна.

Зураг 11. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын шалтгаант нас баралт



Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын талаарх нийгэм дэх мэдлэгийг үнэлсэн үр дүн. Бидний судалгааны явцад Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчдийн 52.3% (n=176) нь 15-24 насны иргэд байсан бөгөөд мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын талаарх мэдлэгийг үнэлэх асуумж судалгааны 63% (n=191) нь 15-19 нас, 37% (n=112) нь 20-24 насныхан, дундаж нас 19±2 байна. Ам бүлийн хувьд 50.2% (n=152) нь 4-5 ам бүлтэй, 25% (n=76) нь 2-3 ам бүлтэй, 24.7% (n=75) нь 5-с дээш ам бүлтэй, хүйсийн хувьд 65% (n=197) эрэгтэй, 35% (n=106) эмэгтэй хүмүүс уг судалгаанд хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 97% (n=294) нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын талаар ямар нэгэн байдлаар (найз нөхөд, гэр бүлийнхэн, анги хамт олон, цахим орчин, олон нийтийн хэрэгсэл) сонсож байсан бол 71.3% (n=216) нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын нэр төрлийн талаар мэдээлэлтэй, 28.7% (n=87) мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын мэдээлэл дутмаг /газ, электрон тамхи, цавуу/ байсан ба 75.6%(n=226) нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой хууль эрх зүйн тодорхой мэдээлэлтэй байна.

Зураг 12. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэж байсан эсэхийг харуулсан график



Судалгаанд оролцсон хүмүүсийн 32% нь мансууруулах бодис хэрэглэж байсан бол, 4% нь ахуйн хэрэглээний газ хэрэглэж байсан байна.

Зураг 13. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн шалтгааныг харуулсан график



Мөн нийт судалгаанд хамрагсдын 32% (n=96) нь мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэж үзсэн, 64% (n=194) нь хэрэглэж байгаагүй байсан бөгөөд мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэх болсон шалтгааныг тодруулахад 40% (n=120) нь найз нөхөд, өөрийн сонирхлоор хэрэглэсэн бол 31.7% (n=96) нь цаашид хэрэглэх сонирхол байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хүснэгт 2. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн хүмүүсийн гэр бүлийн дундаж орлогыг харуулсан байдал.

Гэр бүлийн орлого	**n; %**	**Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн эсэх**	
		Тийм	**Үгүй**
1-с доош	22	0	22
2-3 сая	151	45	103
4-5 сая	102	44	49
5-с дээш	28	7	20
Нийт	**303**	**96**	**194**

Мансууруулах, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн хүмүүсийн гэр бүлийн дундаж орлогыг авч үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа гараагүй. Гэсэн хэдий ч 92.7% (n=89) нь дунджаас дээш орлоготой буюу 2-5 сая төгрөгийн цалинтай гэр бүлийн хүмүүс хэрэглэж байсан байна.

Олон улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нийтлэг нэршил нь Наркотик юм. “Narkotikos” гэдэг нь мансуурах, мэгдэх, бэгтрэх гэсэн Грек хэлний үг, мансуурахад хүргэдэг ургамлын болон синтетик үүсэл гаралтай янз бүрийн бодисын бүтэц бүхий бүлэг (зүйл) хэрэглэгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл мансуурах нөлөөлөл

үзүүлдэг буюу хэт баяртай, жаргалтай сэтгэгдэл төрүүлж байгаа нь объектив нөхцөл байдалтай үл нийцэх байдлыг бий болгодог бодисыг мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодис гэж ойлгоно.

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуульд зааснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Конвенц, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны Конвенцын жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг ойлгоно”.

Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 1961 оны нэгдсэн конвенц, түүний I, II жагсаалт, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенц, түүний I, II, III, IV хавсралтад орсон байгалийн болон нийлэгжүүлсэн бодисуудын хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаврыг нь харгалзан мансууруулах үйлчилгээтэй бодис болохыг нь тогтоож хяналтаас гадуур (эмнэлэг, судалгаа шинжилгээний бус зорилгоор) хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм бэлдмэлүүдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэмээн тооцдог.

Хүний сэтгэцэд үйлчлэх байдлаар нь:

- Төв мэдрэлийн системийг дарангуйлагч буюу оюуны идэвхийг сааруулах, хэт тайвшруулах, нойрсуулах үйлчилгээтэй бодис;
- Төв мэдрэлийн системийг өдөөгч буюу сэтгэцийн идэвхийг сэргээж, сэтгэл санааг хий хөөрөлд оруулах үйлчилгээтэй бодис;
- Солио үүсгэгч буюу хий юмс үзэгдүүлж, сонсогдуулах үйлчилгээтэй бодис;
- Сэтгэцийн хосолмол үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй бодис гэж тус тус ангилна.

Ахуйн хэрэглээний хорт бодисын ойлголт:

Зан үйлийн эмгэгтэй зарим хүүхэд, залуучууд өөрийн амьдралын буруу дадал, зан үйлээсээ болж дэгдэмхий бодисуудыг хэрэглэж сэтгэлийн хөөрөлд орж уг дэгдэмтгий бодисынхоо хараат байдалд орохыг дэгдэмхий бодсонд донтох өвчин гэдэг. Өөрөөр хэлбэл, дэгдэмхий уусгагч бодисыг замбараагүй /зохисгүй/ хэрэглэж түүнд донтох зан үйлийн эмгэгийг ингалянтад донтох өвчин гэж нэрлэдэг.

Ахуйн хэрэглээний хорт болон сэтгэц идэвхт, дэгдэмхий химийн бодисыг дараах байдлаар бүлэглэн авч үзсэн байна. Үүнд:

- Аэрозоль, Газолин, /нефтийг нэрэх замаар гарган авсан шингэн бодис/,
- Синтетик цавуу,
- Органик уусгагчид химийн цэвэрлэгч бодис,

- Нитробензол ба нитрат,
- Толуол ацетон, бензол, галогенчлагдсан нүүрстөрөгчийг агуулсан бусад ингалянт гэж хуваан авч үздэг.

Улсын хэмжээнд Нийт 149 хүн /11-26 нас/ 27 эмэгтэй,122 эрэгтэй хүүхэд хэрэглэсэн гэж бүртгэгдсэн байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт үйлчилгээтэй эмийн ойлголт:

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн а/28 тушаалын хавсралтаар хүн амын эмчилгээнд хэрэглэгдэж байгаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад мансууруулах эм 13 төрөл, сэтгэцэд нөлөөт эм 33 төрөл багтсан.

Хэрэглэгчдийн дунд **“Анданте”** эмийг “дан”, “дандар ах”, “дандрак” гэх жаргон хэллэгээр хэлж ярилцдаг, сүүлийн үед эмийн олдоц багасаж байгаа учраас үнэ нэмэгдэх болсон. Хэрэглэгч нар нунтаг байдлаар хамраар сорж хэрэглэснээр сэтгэл хөөрөх, дуу хөгжим сонсох, мэдрэмтгий болох мэдрэмж төрж, бие махбод эмд дасал болох замаар хэрэглэгч, донтогчдын хүрээ өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд үүсэж бий болсоор байна.

ЭМЯ-ны сайдын 2015.02.24-ны өдрийн 68 тоот тушаалын 2-р хавсралтаар “Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-д үйлчлэгч бодист нь “Залеплон” агуулагдсан эмийг оруулснаар “Анданте” эмийг хууль бусаар олж авч хэрэглэдэг этгээдүүдэд хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдсэн байна.

Натрийн Бензоат /*Mu Mu*/ буюу Натрийн давсны бензоатын хүчил нь үнэргүй, амтгүй, цагаан өнгөтэй, нунтаг хэлбэрийн бодис юм.

Натрийн бензоат нь байгаль дээр ургамал, амьтны эд, эсэд тодорхой хэмжээгээр агуулагддаг ба алим, үзэм, усан үзмийн төрлийн ургамалд түгээмэл агуулагдаж төмсний гурил буюу крахмалтай идэвхтэй урвалд ордог.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд илрэх нийтлэг шинж

- Нүдний хүүхэн хараа томрох, жижгэрэх
- Зүг чиг, орон зайн баримжаа алдагдах
- Булчин шөрмөс хөших, татах
- Өвдөлтийн мэдрэмж буурах
- Зүрхний цохилт хурдсах
- Үг яриа олширч, эмх цэгцгүй болох
- Хамрын үзүүр, арьс загатнах
- Цусны даралт багасах буюу ихсэх
- Амьсгал дарангуйлагдах, судасны цохилт, амьсгалын тоо цөөрөх

• Түгшүүрт автан, тогтворгүй байдалд орох
• Биеийн халуун нэмэгдэх, хөлрөх
• Ам хатах, шүдээ хавирах
• Хамаг бие дагжин чичрэх
• Судсаар тарьсан тохиолдолд, зүүний мөр үлдэнэ.

Гадаад нөхцөл байдал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын тайланд дэлхийд 247 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, үүнээс 29 сая хүн нь уг бодисоос шууд хамааралтай болж, минут тутамд 1 хүн амь насаа алдаж байгаа талаар дурдсан байна.

Биеэ үнэлэгч, халаасны хулгайчдаар зуучлуулан худалдан авч шуудан илгээмж, карго, хүнсний бүтээгдэхүүнд нуух аргаар

- ICE буюу Мөс
- Гашиш
- Экстази

зэргийг тээвэрлэн Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улс, Оросын Холбооны Улс гэсэн шинэ суваг, маршрут үүсгэж болзошгүй байна. БНХАУ-ын Эрээн хотод ажиллаж амьдарч буй монгол улсын иргэд, тэр дундаа биеэ үнэлэгч, халаасны хулгайч нараар дамжуулан мансууруулах бодисын төрөлд орох ICE буюу Мөс, Гашиш, Экстази зэргийг тээвэрлэн Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж байна. Сүүлийн жилүүдэд Бээжин, Гуанжоу хот уруу зорчих хандлага ихсэж, үүнийг дагаад Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улс, Оросын Холбооны Улс гэсэн шинэ суваг, маршрут үүсгэж болзошгүй байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хоорондын 2017-2020 онд Хамтран ажиллах тухай хөтөлбөрийн 11 дүгээр зүйлд “Талууд хоёр улсын хил орчмын хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тусгасан. Үүнээс

- 1998-2016 онд гадаад улс оронд 128 иргэн,
- 2017 онд 42 иргэн шалгагдсанаас БНХАУ-д 38, Сингапурт 2, ОХУ-д 2
- БНХАУ-д 36, Словакт 1, нийт 37 иргэн хорих ял эдэлж байна.

ХТМБ-ЫГ ХУУЛЬ БУСААР НЭВТРҮҮЛЖ БУЙ ЗАМ, ЧИГЛЭЛҮҮД

Авто, төмөр замаар

БНХАУ-аас:	ОХУ-аас:	Зүүн өмнөд азиас:
Замын-Үүд боомт,	Буянт-Ухаа боомт	Буянт-Ухаа боомт

Гашуунсухайт боомт, Алтанбулаг боомт

Гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл

Монгол улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг өсөж байгаад дараах шалтгаан нөхцөлүүд нөлөөлж байна. Үүнд:

Хуульд заасан хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл бага, ялын бодлого 2 хөрш орноосоо бага байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг ялын бодлогоор саармагжуулах, таслан зогсоох нөлөөллийг багасгаж байна. Ихэнх улс орнууд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаа ялын бодлогоороо дамжуулж явуулдаг. Ялангуяа хар тамхи,мансууруулах бодисыг хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх ял шийтгэл өндөр байдаг. Монгол улсад хилээр мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгт оногдуулах хуульд заасан ялын хэмжээ 2 хөршийнхөөсөө болон бусад орнуудаас харьцангуй бага, мөн мансууруулах бодис хэрэглэсэн боловч биеэс нь бодис илрээгүй тохиолдолд зөрчилд тооцож зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг өсөх шалтгааны нэг болж байна.

Хар тамхи мансууруулах бодисын уламжлалт хэрэглээтэй 2 том хөрш рүүгээ тус улсын иргэд визгүй зорчдог болсон,тодорхой хугацаанд ажиллаж амьдардаг болсон,мөн Гадаад улс оронд олон тооны оюутан, сурагч, иргэд суралцаж, ажиллаж байгаа нь хар тамхитай холбоотой буруу зуршилтай болж түүнийгээ Монгол улсад буцаж ирээд бусад найз нөхдөө татан оруулж байна.

Манай орны зарим нутаг дэвсгэрт мансууруулах төрлийн ургамал хяналтгүй ургадаг ба төсөв хөрөнгөгүйн улмаас устгах ажил хангалттай зохион байгуулагдахгүй байгаа нь хүүхэд, залуучууд хээр, талаас түүж бэлтгэх явдал таслан зогсоогдохгүй байна.

Хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, цахим сүлжээнд энэ төрлийн мэдээлэл хяналтгүй цацагддаг, мөн телевизээр хэрэглэж байгаа байдлыг ямар нэг хязгаарлалтгүй үзүүлдэг.

Иргэд богино хугацаанд их хэмжээний ашиг олох, орлогын эх үүсвэртэй болох зорилгоор энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон буюу хамааралтай болсон иргэнийг Монгол Улсад эмчлэх байгууллага, туршлага байхгүй байгаа нь хорт зуршлаас нь татгалзуулж чадахгүй байна.

“Монгол шуудан” ХК дахь гаалийн хяналтын бүсэд ашиглаж байгаа “R-SCAN”, Буянт-Ухаа дахь “DHL” шуудан илгээмжийн газарт ашиглагдаж байгаа “Fiscancmex-t 100100” гэсэн рентген төхөөрөмжүүдэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм,

бодисын дээжийг нүдэнд харагдах ил байдлаар болон нуух хэлбэрээр нэвтрүүлэн шалгуулахад өнгөний ялгарал өгөхгүй, ачаа бараанаас ялгагдаж харагдахгүй, техникийн шаардлага хангахгүй байгаа нь хар тамхи, мансууруулах бодис хилээр нэвтрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

ХОЁР. ЧИНГЭЛТЭЙ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН МАНСУУРЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны хүрээнд Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байдаг ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулан суралцагчдаас мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөд бодисын талаарх ойлголт, мэдлэгийг асуулга болон ярилцлагын арга хэрэглэж тодорхойлсон. Өмнө нь сурагчдын ойлголт, мэдлэгийг судалж байсан байна. Тухайлбал, С.Сарангэрэл нарын 2019 онд хийгдсэн “Мансууруулах бодисын талаарх өсвөр үе, залуучуудын мэдлэг, хандлага, хэрэглээ” сэдэвт судалгаанд 3 хүүхэд тутмын 1 нь хангалтгүй мэдлэгтэй байна гэж дүгнэсэн бол бидний судалгааны үр дүнгээр 4 хүүхэд тутмын 1 нь хангалтгүй мэдлэгтэй байна гэсэн судалгаа байсан бол 2025 оны байдлаар энэ нь хүүхэд бүр тодорхой ойлголт, мэдээлэлтэй болсон байх бөгөөд ингэхдээ ихэвчлэн мансуурдаг, гоё болдог гэж дуулсан гэх байдлаар ерөнхий ойлголттой байв.

Гоё болдог гэх ойлголт нь хэрэглэж үзэх эрмэлзлийг төрүүлэх нь гарцаагүй. Энэ агуулгаар Чингэлтэй, Хан-Уул дүүргийн өсвөр үеийнхний мэдлэг, мэдээлэл тодорхойлогдож байгаа нь өндөр эрсдэлтэй байгааг илэрхийлнэ.

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2020-2024 онд мансууруулах бодис хэрэглэсэн нийт 113 тохиолдол бүртгэгдсэнээс 60 буюу 53.1% хувьд насанд хүрээгүй хүүхэд байна. Үүнээс 88,4% хувь нь эрэгтэй, 11,6% хувь нь эмэгтэй хүүхэд байсан бол БГД-ийн хэмжээнд 2022-2024 онд 14 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнээс 78% эрэгтэй, 21 хувь нь эмэгтэй хүүхдүүд

Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 74 өсвөр насны хүүхэд мансууруулах бодис түүнтэй адилтгах эм бусад зүйлс хэрэглэсэн байна.

Тебантин гэх худалдааны нэршилтэй Габапентин Код АТХ: N03АХ12 бүхий жороор олгодог эмийг яагаад өсвөр насны хүүхдүүд хэрэглэх болов, тухайн эмийн шинжилгээний олон улсын арга, аргачлалын талаар болон 2020-2024 оныг хүртэлх ЧД-ийн 1-19-р хороо, ХУД-ийн 1-20 хорооны хэмжээнд өсвөр насны **34** мансуурсан хүүхдүүдийг судалгаанд хамруулахад зарим мансууруулах үйлчилгээ бүхий эмийн талаарх мэдээлэлтэй байсан нь анхаарал татаж байв. Тухайлбал, Тебантин гэх худалдааны нэршил бүхий Габапентин нь (олон улсын нэршил -үндсэн үйлчлэгч бодис) 300мг, 600 мг савлагдсан хатуу капсул бүхий жороор олгогддог эм. Код АТХ: N03АХ12 (Хэсэгчилсэн эпилепси эсвэл насанд хүрэгсэд болон 12 дээш насны хүүхдийн хоёрдогч тархмал бус эпилепсийн үед дан эмчилгээнд хэрэглэдэг.) Тун хэтрэлтийн үед толгой эргэх, юм давхар харагдах, хэл яриа өөрчлөгдөх, нойрмоглох, бие сулрах, зөөлөн суулгах шинж илэрдэг.

Gabapentin tab-г бүртгэлийн материал болон USP (General notices and requirments)олон улсын арга аргачлалын дагуу шинжилгээг хийж тохирлын тухай мэдэгдлийг MNS ISO IEC 17025;2018 дагуу бичнэ.

Өсвөр насны хүүхдүүдийн хэрэглээд байгаа гэх тебантин эмийн янз бүрийн төлөв байдалд байгаа эмийн бодисын бүтцийг таних, тоон агууламжийг тодорхойлох зорилгоор Nerveseiz худалдааны нэршил бүхий Gabapentin 300 мг дээжийг стандарт бодистой харьцуулан (K.C Laboratories working standard Gabapentin USP batch № WS/GAB/085 -99.8%) “TP FW, CARVER” багажаар дээжийг бэлтгэн, Thermo scientific “NICOLET IS 10 FTIR” нил улаан туяаны спектрофотометр багажид бичигдсэн дүнг харьцуулахад трансмитанс нь Габапентины стандарт дээж-10.87 буюу Caffeine 99%/DRIFTS/, Габапентины дээж-11.76 буюу Caffeine 99%/DRIFTS/ байсан бөгөөд нил улаан туяаны гэрлийн мужид эмийн бодисын молекулын функциоаль групп, гэрэл нэвтрэх чадвар, давтамжийг, шингээлт зэргийг стандарт бодистой харьцуулан тодорхойлоход гэрэл шингээлтийн хамгийн утга нь ойролцоо байна.

Сүүлийн жилүүдэд дээрх эмийн бэлдмэлийг хууль бусаар олж авч 5 ширхэг капсул эмийг 0.9% натрийн хлоридоор найруулан /Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Дугаар /ДШМ/775 хэргийн индекс - 2302008020072 / зориулалтын бус газар тарьж хэрэглэснээс артери, вений судсыг бөглөх, улмаар амь насаа алдах, хөдөлмөрийн чадваргүй болох нийгэмд аюулын харанга дэгдээх, гараа тайруулах зэрэг эрсдэлт зүйлүүд өсвөр насны хүүхдүүдийн дунд ихээр гарах боллоо.

Мансуурагч хүүхдүүдийн тоо

Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүргийн хэмжээнд 2022 онд 18, 2023 онд 32, 2024 онд 74 зэргээс өссөн үзүүлэлттэй байна.

Зураг №...Мансуурсан байдлаар нь үзвэл

Хар тамхи хэрэглэсэн-1, будаг шингэлэгч-17, Газ-22, цавуу-4 тебантан эм-3. Үүнээс харахад голлож хэрэглэн донтож байгаа хорт бодис нь газ, будаг шингэлэгч байна. Эдгээр химийн найрлага бүхий бодисууд нь хордлогод хүргэж, хүүхдүүдийн амь насыг ч эрсдэлд оруулах чадамжтай аюултай бодисууд юм.

Судалгаанаас үзэхэд, мансуурах хам шинжид өртсөн хүүхдүүд мансуурах мэдрэмжийг улам гүнзгийрүүлэн мэдрэх эрмэлзэл нь ирээдүйн донтогчийг бий болгож байна. Улмаар мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эмийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсээр байх аж.

ГУРАВ. МАНСУУРАЛ БА ӨСВӨР ҮЕ

Орчин үед өсвөр үеийнхэн хар тамхи, мансууруулах бодистой холбогдох эрсдэлд ихээр өртөж байна. Дэлхий нийтээр энэ төрлийн гэмт хэрэг, эрүүл мэндийн асуудал улам бүр нэмэгдэж байгаа нь хүүхэд, залуучуудын дунд урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах шаардлагыг бий болгож байна.

Судалгааны ажлын зорилго нь өсвөр үеийнхний хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх шалтгаан нөхцөл, эрсдэлт хүчин зүйлсийг судалж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөтэй арга замыг тодорхойлох явдал юм. Өсвөр нас бол хүний сэтгэлзүй, бие махбодын хурдацтай өөрчлөгдөх үе тул гаднын нөлөөлөлд амархан автдаг эмзэг үе шат юм. Орчин үед хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ өсвөр үеийнхэн дунд нэмэгдэх хандлагатай байгаа нь нийгмийн анхаарал татсан ноцтой асуудал болоод байна. ДЭМБ-ын 2022 оны тайланд дурдсанаар дэлхий даяар хар тамхи хэрэглэж буй хүмүүсийн 10 гаруй хувийг 15–24 насны залуус эзэлж байгаа нь урьдчилан сэргийлэх бодлого, боловсролын ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна (World Health Organization, 2022).

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Олон улсын гэрээ, баримт бичгүүд цөөнгүй батлагдсан. НҮБ-ын ивээл доор 81 улс орон оролцон “Мансууруулах эмийн тухай Нэгдсэн конвенц[9] -ийг 1961 оны 3 дугаар сарын 25-ний өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13- ний өдөр хүчин төгөлдөр болсон, 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулж, уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон[10].

Уг конвенц нь мансуурал үүсгэх чадвартай бодисууд болох опоид, каннабиноид ба кокайныг хууль бусаар үйлдвэрлэх, дамлан худалдаалах, хууль бусаар ашиглах зэрэг 51 заалт бүхий олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг юм. Энэхүү мансууруулах бодис агуулсан ургамлыг тарималжуулахыг хязгаарлаж, хяналт тавих системийг бий болгожээ. 1961 оны конвенцод нэгдэн орсон талууд мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй гэж үзсэн бодис, эм бэлдмэлийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад нэн даруй хүргэх үүрэгтэй. Энэ конвенцын 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний эргэлтийг хууль ёсны болон хууль бус гэж ангилах үндэслэлийг бүрдүүлж өгчээ. Конвенцын 2 дугаар зүйлд хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналтад байна” гэж заажээ.

---

[9] UN United Convention on narcotic drugs, 1961 – Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон.

[10] Монгол улс 1990.12.06-нд нэгдэн орсон. Төрийн мэдээлэл тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 957-996 дахь тал

Мөн зүйлийн 5 дахь хэсэгт “гэрээнд нэгдэн орсон талууд нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлгийн болон эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглахаас бусад зорилгоор мансууруулах бодисыг худалдаалахыг хориглохоор” заасан байна. Уг конвенцоор үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлаж, хууль бус эргэлтийн аливаа хэлбэрийг хориглосон юм. Энэхүү конвенцод заасан журмын дагуу мансууруулах бодисын олон улсын худалдаа нь Мансууруулах бодист хяналт тавих олон улсын хорооны хяналтад байхаар заасан байна. “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенц[11] 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Вена хотноо 71 орны төлөөлөгчид оролцон баталж 1976 оны 8 дугаар сарын 16-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон[12].

Энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголт[13] тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэдгийг зааглах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Конвенцын 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч тал нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах илүү тохиромжтой арга гэж үзвэл эмнэлгийн болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд шаардлагатайгаас бусад тохиолдолд түүнийг худалдаалахыг хориглох”[14] тухай тусгаснаас гадна хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналт дор байна” гэжээ.

Уг конвенцоор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан юм. Энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм.

Хар тамхи, мансууруулах бодис гэдэг нь хүний мэдрэлийн тогтолцоонд шууд нөлөөлж, сэтгэл зүй, зан үйлийг өөрчилдөг химийн бодисууд юм. Өсвөр үе бол хувь хүний нийгэмшил, зан төлөв бүрэлдэх чухал үе шат бөгөөд энэ үед сэтгэл зүйн хувьд эмзэг, бусдын нөлөөнд автамтгай байдаг. Иймээс энэ үед буруу мэдээлэл, сөрөг нөлөө бүхий хүрээлэлд орсон тохиолдолд мансууралд өртөх эрсдэл өндөр байна.

Хар тамхи хэрэглэх зан үйлийн шалтгаан нь олон хүчин зүйлсийн огтлолцлоор илэрдэг бөгөөд үүнд хувь хүний сэтгэл зүйн эмзэг байдал, гэр бүлийн

---

[11] Энэ конвенцыг Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

[12] Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон. “Төрийн мэдээлэл” тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 1033-1063 дахь тал

[13] Дурдсан конвенц. 5 дахь тал

[14] Мөн тэнд

орчин, боловсрол, хамт олон, нийгмийн дарамт, мэдээллийн орчин зэрэг гүнзгий нөлөө үзүүлдэг. Донтох хэв шинж, түүнийг өдөөж буй дотоод ба гадаад сэдэл, тэдгээрийн харилцан үйлчлэлийн зүй тогтол, зан үйл ба донтолтын механизмын онолын үндэслэлийг тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон зан үйлийг засах сэтгэл зүйн зөвлөгөөний практикт ихээхэн ач холбогдолтой.

Донтолт нь тодорхой зүйлд (бодис, үйл ажиллагаа, зуршил) хэт хамааралтай болж, энэ нь хүний өдөр тутмын амьдрал, эрүүл мэнд, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхийг хэлдэг. Донтолт нь биологийн, сэтгэлзүйн болон нийгмийн хүчин зүйлсээс шалтгаалдаг.

Хар тамхины донтолт нь сэтгэл зүйн олон төрлийн онолд тайлбарлагдаж ирсэн бөгөөд энэ нь хувь хүний дотоод сэдэл, зан үйлийн тогтолцоо, орчны нөлөөллийн огтлолцлоос үүдэлтэй цогц эмгэг хамаарал юм. Донтох эмгэгийн гол онол болон хар тамхи хэрэглэх зан үйлийн харилцан хамаарлын талаар дараах чиг хандлагууд байна. Үүнд:

Өвчний загвар онол (Disease Model of Addiction): Өвчний загвар онолд донтох явцыг бие махбодын болон тархины функцийн хяналт алдагдахтай холбоотойгоор тайлбарладаг. Хар тамхи нь тархины урамших системд нөлөөлж, допамины түвшин хэт ихээр нэмэгдүүлснээр таашаалын төвүүдийг хэт сэргээдэг. Энэ нь дахин хэрэглээ рүү түлхэх хамаарал үүсгэдэг бөгөөд улмаар хүний зан үйлийг хянах механизм алдагдаж, хэрэглэхийг зогсоох боломжгүй болдог (Leshner, 1997). Өвчний загварын гол онцлог нь донтолтыг өөрөө сонгосон, сул дорой зан авир бус харин эмгэг гэж хүлээн зөвшөөрдөгт оршдог.

Зан үйлийн донгийн онол (Behavioral Addiction Theory): Энэхүү онолд донтох зан үйл нь нөхцөлдүүлэлт ба шагналын тогтолцооны үр дүнд хөгждөг гэж үздэг. Хар тамхи хэрэглэх нь тухайн нөхцөл байдалд шууд таашаал авчирч, даралт, стрессийг бууруулах мэдрэмж төрүүлдэг. Энэ мэдрэмж дахин мэдрэх хүсэлтэй уялдаж, тухайн үйлдлийг дахин давтахад хүргэдэг. Зан үйл ба сэтгэл хөдлөлийн хоорондын шууд холбоог тайлбарлахын зэрэгцээ, орчны нөхцөл болон хариу урвалын хэлбэрт онцгой анхаарал хандуулдаг (Grant et al., 2010).

Импульс хяналтын онол (Impulse Control Theory): Энэ онолд донтох зан үйл нь хувь хүний импульс хянах чадварын сулралаас улбаатай гэж үздэг. Импульсив хүмүүс сэтгэл хөдлөлөө удирдах, төлөвлөх, хүлээх чадвар сул тул хар тамхины шагналт мэдрэмжид өртөх үед хязгаарлах чадваргүй болдог (Evenden, 1999). Хар тамхи хэрэглэсний дараа үүсэх богино хугацааны тайвшрал нь дараагийн хэрэглээг өдөөдөг сэтгэлзүйн давталт үүсгэдэг бөгөөд энэ нь донтох хэв шинжийн үндэс болдог.

Нийгмийн суралцахуйн онол (Social Learning Theory): Bandura (Bandura, 1977) (1977)-ийн нийгмийн суралцлын онол нь хүний зан үйл нь ажиглалт, дуурайлт,

баталгаажилтын үр дүнд бүрэлддэг гэж үздэг. Хар тамхи хэрэглэх зан үйл нь орчны хүмүүсийн зан авирыг дуурайх, хамт олны нөлөөлөлд автсан, эерэг хүлээн зөвшөөрөл авсан нөхцөлд төлөвшдөг. Ялангуяа өсвөр насны үед үе тэнгийн нөлөө, медиа орчны шууд нөлөөллөөр энэ төрлийн зан үйл амархан сууж, хууль бус ч гэлээ хүлээн зөвшөөрөгдсөн зан үйлийн нэг хэлбэр болон хөгждөг.

Танин мэдэхүйн буруу төлөвшлийн онол (Cognitive Distortion Theory):** Энэхүү онол нь донтох зан үйлийн цаана орших буруу итгэл үнэмшил, бодлын алдаа, сэтгэл зүйн хамгаалалттай холбоотой. Жишээлбэл, "Би ганцхан удаа хэрэглэнэ", "Би өөрийгөө хянаж чадна", "Хүмүүс намайг шүүмжлэхгүй" зэрэг бодлууд нь донтох зан үйлийг зөвтгөх, өөрийгөө хуурсан сэтгэл зүйн механизмын илрэл болдог. Ийм итгэл үнэмшил нь хар тамхи хэрэглэхийг дэмжих, сэтгэл зүйн дархлааг бууруулах сөрөг үр дагавартай (Beck et al., 1993).

Дээрх онолууд нь тус бүртээ өөрийн хүрээнд тайлбар өгдөг боловч хар тамхины донтолтыг бүрэн ойлгоход эдгээрийг нэгтгэн авч үзэх шаардлагатай. Сэтгэл зүйн, нийгмийн, зан үйлийн хүчин зүйлсийг хослуулан дүн шинжилгээ хийснээр судалгаа, оношилгоо, сэтгэл зүйн үйлчилгээний чанарыг нэмэгдэх боломж бүрдэх юм.

Донтох эмгэгийг тайлбарласан үндсэн онолуудын хүрээнд хар тамхи хэрэглэх зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн хүчин зүйлсийг задлан шинжлэх нь үндсэн зорилт юм. Тухайлбал, өвчний загвар онол нь донтох сэдлийг физиологийн шалтгаантай хамааруулдаг бол зан үйлийн донгийн онол нь тухайн зан үйлийн нөхцөлдүүлэлт, шагналт хүлээлтийн тогтолцоог тайлбарладаг. Харин импульс хяналтын онол болон танин мэдэхүйн онолууд хувь хүний дотоод хямрал, сэтгэл зүйн механизмын эмзэг байдлыг онцолдог.

Манай орны хувьд эдгээр онолууд харилцан уялдаатайгаар илэрч байгаа нь анхаарал татдаг. Нэг талаас, хар тамхины хэрэглээ нь хувь хүний сэтгэл зүйн эмзэг байдал, ганцаардал, стресс, сэтгэл гутрал зэргээс үүдэлтэй импульсив зан үйлээр илрэх хандлагатай. Нөгөө талаас, үе тэнгийнхэн, олон нийтийн сүлжээ, сошиал орчны нөлөөгөөр дуурайлт, суралцлын үр дүнд энэ зан үйл улам бүр баталгааждаг. Bandura-ийн нийгмийн суралцлын онол энэ үзэгдлийг нарийн тодорхой тайлбарлаж өгдөг.

Түүнчлэн, хар тамхины хэрэглээ нь зөвхөн тухайн хүний сэтгэл зүйн хүчин зүйлээр хязгаарлагдахгүй, тухайн хүний амьдралын нөхцөл, боловсрол, гэр бүлийн орчин, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн хүчин зүйлсийн нөлөөгөөр улам даамжирдаг. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүүхэд насыг асрамж халамжгүй өнгөрүүлсэн хүмүүсийн дунд мансууруулах бодис хэрэглэх магадлал өндөр байдаг нь сэтгэл зүйн орчин, нийгмийн хүчин зүйлсийн огтлолцлын үр дагавар болохыг харуулж байна.

Хар тамхины донтолт нь тархины шагналын системийг хэт өдөөх, түүнд хэт хамааралтай болох механизмтай бөгөөд энэ нь хүний зан үйлийг давтамжтайгаар нөхцөлдүүлдэг. Энэ үйл явц нь "сурсан хариу урвал" болж хувирдаг бөгөөд өөрийн ухамсар, хүсэл зоригоор хянах боломжгүй болтлоо зан үйл нь гүнзгийрдэг. Иймд эмгэг хамаарал нь зөвхөн нэг талын шалтгаанаар бус олон түвшний (биологийн, сэтгэл зүйн, нийгмийн) хүчин зүйлсийн нэгдэл юм.

Аливаа шинэ зан үйлийг зуршил болгон хэвшүүлэх дундаж хугацааг 21-66 хоног гэж үздэг. Донтолт нь сэтгэлзүйн болон бие махбодын аль аль талаасаа нөлөөлдөг учир энэ хугацаанд тасралтгүй эмчилгээ, дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай.

Энэхүү дүн шинжилгээгээр донтолтыг нэгэн төрлийн зан үйлийн эмгэг хамаарал хэмээн үзэж, сэтгэл зүйн оношилгоо, урьдчилан сэргийлэлт, зөвлөгөөний тогтолцоо, нийгмийн үйлчилгээний шинэчлэл шаардлагатай байгааг дүгнэж болох юм.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвөөс эрхлэн гаргасан статистик мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ:

2022-2025онд улсын хэмжээнд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой нийт 788 гэмт хэрэг үйлдэгдсэний 86.6 хувь нь нийслэлд бүртгэгджээ.

Нийт гэмт хэргийн тоо, нийслэл болон орон нутгийн тоог харуулж байна.





Төрлөөр нь авч үзэхэд:



Хар тамхи, мансууруулах бодистой бүртгэгдсэн гэмт хэрэг үйлдэгчдийг насаар нь ангилахад:

		2022 он	2023 он	2024 он	2025.03	Нийт
Нас	14-15	2	3	3		8
	16-17	4	3	8		15
	18-24	108	71	91	12	282
	25-29	64	61	45	8	178
	30-34	38	40	41	3	122
	35-39	13	25	19	3	60
	40-44	8	13	6		27
	45-49	2	3	3		8
	50-54			4		4
	55-59			1		1
	60-64		1			1
	65-69					0
	70 ба түүнээс дээш					0

Дээрхээс үзэхэд Хар тамхи гэдэг нь зөвхөн хувь хүний сонголтын алдаа биш. Энэ бол өвчин. Энэ нь хүний бие махбод, сэтгэл зүй, гэр бүл, нийгэмд ноцтой хор хохирол авчирдаг. Харамсалтай нь, сүүлийн жилүүдэд манай улсад хар тамхитай холбоотой хэрэг огцом нэмэгдэж байна. Доорх графикаас бид энэ бодит нөхцөл байдлыг тодорхой харж болно:



Тоон үзүүлэлтүүд

- 2018 онд хар тамхитай холбоотой 120 хэрэг бүртгэгдэж байсан бол 2024 онд энэ тоо 370-д хүрч, бараг 3 дахин өссөн байна.

- Үүний хажуугаар, эмчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн тоо ч нэмэгдэж байгаа нь нийгмийн дэмжлэг, ойлголт нэмэгдэж байгааг харуулж байна. 2018 онд 30 хүн эмчилгээ хийлгэсэн бол 2024 онд энэ тоо 100-д хүрсэн байна.

Асуудлын судалгаа

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой хэрэг үйлдсэн хүүхдийн тоо нэмэгдэж байгаа талаар Цагдаагийн ерөнхий газар мэдээлж байна. 2024 онд бүртгэгдсэн мансууруулах бодистой холбоотой 200 гаруй хэргийн 15 хувь нь 18 нас хүрээгүй этгээдтэй холбоотой байсан бөгөөд энэ нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байгааг илтгэж байна. (ЦЕГ, 2024).

Урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлүүд

1. Боловсролын байгууллагын оролцоо

Сургуулийн хүрээнд хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгийн тухай хичээл, сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах нь чухал. Судалгаанаас үзэхэд, хар тамхины талаарх мэдлэгтэй өсвөр насныхны дунд хэрэглээний магадлал 60 хувиар бага байдаг (UNODC, 2021).

2.Гэр бүлийн оролцоо

Эцэг эхийн анхаарал, харилцаа, хяналт нь хүүхдийн сөрөг нөлөөлөлд автах эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй. Судалгаагаар гэр бүлийн оролцоо өндөртэй хүүхдүүдийн дунд хар тамхи хэрэглэх магадлал 2–3 дахин бага байгааг тогтоожээ (Brook et al., 2020).

3. Олон нийт, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хар тамхины эсрэг нийгмийн сурталчилгаа, бодит жишээ, үр дагаврыг танилцуулж, өсвөр үеийнхний сэтгэхүйд нөлөөлөх нь үр дүнтэй арга юм. Сошиал медиа платформууд дээр эерэг жишээ, уриалга түгээх нь үр нөлөөтэй болохыг харуулсан олон улсын туршлага бий (NIDA, 2023).

4. Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа

Цагдаа, прокурор, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, хамтарсан нөлөөллийн арга хэмжээ урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлдэг.

Улсын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн 229 гэмт хэрэгт нийтдээ 229 хүн холбогдон шалгагдсанаас, 15 хүртэлх насны хүүхэд 2, 16-17 насны 7, 18-24 насны 104, 25-29 насны 59, 30-34 насны 35, 35-39 насны 12, 40-44 насны 8, 45-49 насны 2, 2023 онд бүртгэгдсэн 239 гэмт хэрэгт нийтдээ 200 хүн холбогдон шалгагдсанаас 15

хүртэлх насны хүүхэд 1, 16-17 насны 3, 18-24 насны 59, 25-29 насны 56, 30-34 насны 35, 35-39 насны 30, 40-44 насны 12, 45-49 насны 3, 60-64 насны 1, 2024 онд бүртгэгдсэн 254 гэмт хэрэгт нийтдээ 182 хүн холбогдон шалгагдсанаас 15 хүртэлх насны хүүхэд 2, 16-17 насны 4, 18-24 насны 65, 25-29 насны 46, 30-34 насны 34, 35-39 насны 17, 40-44 насны 6, 45-49 насны 3, 50-57 насны 4, 60-64 насны 1 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Өсвөр насны (насанд хүрээгүй) нийт 19 хүүхдийн 16 нь ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид байна.

Дээрх мэдээг нэгтгэн дүгнэвэл: мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт холбогдон цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа өсвөр насны буюу насанд хүрээгүй иргэдийн тоо жил ирэх тус тогтмол өсөж байна. Иймээс насанд хүрээгүй иргэдийн ар гэрээс тэдгээрт тавьж байгаа хяналтыг сайжруулан, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт мансууруулах бодисын хор нөлөө бөгөөд, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тогтмол хичээл, сургалт орох шаардлагатай байна.

ДӨРӨВ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа хар тамхины аюулыг таслан зогсоох талаар арга хэмжээ авч 1912 оны 6 дугаар сарын 27-ны өдөр “Хар тамхи хэмээгч бодис хамаг хортой бузар юм мөн хэмээх тул үүнээс урагш манай Монгол нутагт тэрхүү хар тамхи хэмээгчийг элдэв хүн татаж хэрэглэх ба худалдааны пүүс, дотор газраас худалдан өгөх, манай улсад тарианд тарих явдлыг нэгэн адил чангалан цаазалсугай” хэмээн Богд хаанаас гаргасан зарлиг анх гаргажээ.

Монголд ашиглаж байсан хар тамхины нэг хэсэг нь өрнийн зах зээлээс Хятад худалдаачдаар дамжин орж ирсэн үйлдвэрийн аргаар боловсруулсан хар тамхийг дээдсийн хүрээлэлд голдуу ашиглаж байсан бол гар аргаар боловсруулсан хар тамхийг Сэлэнгэ орчим нутагт жирийн хятад тариачид бага зэрэг хэмжээгээр тарих буюу байгаль дээрээс хар тамхины хольцтой ургамлыг түүх замаар боловсруулан хэрэглэж байжээ.

Мөн 1935 онд Улсын цагдан сэргийлэх байгууллагын Гүйцэтгэх тасгийн тайланд хар тамхи татсан ба худалдсан хэрэгт 239 хүнийг баривчилж, хуулийн хэмжээ үзүүлсэн хэмээн тэмдэглэгдэн үлдсэн байдаг [15].

Монгол Улсад 1993 онд Эрүүгийн хуулинд "Гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулалттай бүлэг" гэсэн ойлголтыг анх удаа хуульчилж өгсөнтэй холбогдуулан Эрүүгийн хэлтсийн бүрэлдэхүүнд Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай тасгийг байгуулсан. Тус тасаг нь хар тамхи, мансууруулах бодис, садар самуун, биеэ үнэлэгч нартай тэмцэх, хүн амь, хүчин, дээрмийн гэмт хэргийг илрүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгч нар ажиллаж эхэлсэн нь Монгол Улсад хар тамхины гэмт хэрэгтэй бодлогын хэмжээнд тэмцэх үндэс суурийн эхлэл тавигдсан.

ЦЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Б/84 тушаалаар Хар тамхитай тэмцэх газрыг Эрүүгийн цагдаагийн албаны бүтцээс гаргаж ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын мэдэлд шилжүүлсэн.

Мөн Засгийн газраас үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой ЦЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/16 тушаалаар Хар тамхитай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 46 орон тоог шинээр баталж Дархан уул, Орхон аймаг дахь Цагдаагийн газар, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Ханбогд сум дахь цагдаагийн тасагт тус бүр 1 эрүүгийн мөрдөгч, Дорноговь аймаг дахь

Цагдаагийн газрын Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын Алтанбулаг сум дахь цагдаагийн хэлтэст тус

15 Эрүүгийн тагнуулын албаны түүхэн товчоо 2009 он, Цагдан сэргийлэх газрын ажлын товч илтгэл

бүр 1 эрүүгийн ахлах мөрдөгчийн орон тоог хар тамхитай тэмцэх чиг үүрэгтэйгээр шилжүүлсэн.

Улсын Ерөнхий Прокурорын 2024 оны А/34 дүгээр тушаалаар Хар тамхитай тэмцэх газрын эрх бүхий албан тушаалтанд Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан ЦЕГ-ын даргын 02 дугаар сарын 21-ний өдрийн А/103 дугаар тушаалаар Мөрдөн шалгах хэлтсийн бүтцэд “Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг”-ийг шинээр байгуулж одоогийн бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулж, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн эргэлтэд хяналт тавих, эм ханган нийлүүлэх төв, эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархац тогтоох, устгал хийх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” НҮБ-ын 1988 оны конвецийн I, II жагсаалтад орсон угтвар бодис, түүхий эдийн эргэлтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд иргэд олон нийтэд хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг ухуулан таниулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хяналт шалгалт, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, захиргааны болон дотоод ажил, аюулгүй байдлыг ханган ажиллах үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, нөхцөл байдлыг гадаад, дотоод нөхцөл байдал, хууль бус эрэлт нийлүүлэлтийн хүрээнд авч үзлээ.

<u>Шалгаж шийдвэрлэсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар</u>

Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт 2016-2024 онд өмнөх жилүүдээс 2-3 дахин өсөж, 2019-2024 онд насанд хүрээгүй 58 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон байна.

Сүүлийн 8 жилийн байдлаар 1772 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 86 хувь буюу 1527 гэмт хэрэг нь Нийслэл хотод бүртгэгдэж, жил бүр 278 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт яллагдагчаар татагдаж шалгагдаж, гэмт хэргийн илрүүлэлт 70,2 хувьтай байна.

Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт 2016-2024 онд өмнөх жилүүдээс 2-3 дахин өсөж, 2019-2024 онд насанд хүрээгүй 58 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон

Сүүлийн 8 жилийн байдлаар 1772 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 86 хувь буюу 1527 гэмт хэрэг нь Нийслэл хотод бүртгэгдэж, жил бүр 278 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт яллагдагчаар татагдаж шалгагдаж, гэмт хэргийн илрүүлэлт 70,2 хувьтай байна. Улсын хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-т заасан мансуурсан гэх үндэслэлээр 2024 онд нийт 306 зөрчлийн хэрэгт 284 хүнд зөрчлийн хэрэг үүсгэж, шийдвэрлэснээс захиргааны журмаар баривчилсан 225, шийтгэврээр торгосон 44

хүн байгаа бөгөөд 4,960,000 төгрөгийн торгууль ноогдуулсан бол сургалтад хамруулсан /насанд хүрээгүй хүн/ 15 хүн бүртгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн хэрэг 41 нэгжээр буюу 7,7 хувиар, холбогдсонf хүний тоо 56 нэгжээр буюу 24,5 хувиар тус тус өссөн байна.

Зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад захиргааны журмаар баривчилсан хүний тоо 68 нэгжээр, сургалтад хамруулсан /насанд хүрээгүй хүн/ 10 нэгжээр буюу 3 дахин тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогчид:

Цагдаагийн байгууллагад 2024 онд энэ төрлийн гэмт хэргийн яллагдагчаа 221 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 буюу 0.4 хувиар өссөн байна. Хүйсийн байдлаар нь авч үзвэл эрэгтэй 194, эмэгтэй 27 хүн бүртгэгдсэн байна. Насны байдлаар авч үзвэл насанд хүрээгүй 13-17 настай 4,9 хувь буюу 11, 18-25 настай 45,7 хувь буюу 101 иргэд тус тус эзэлж байна.

Сүүлийн 8 жилийн хугацаанд Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн 66 гэмт хэргийн 37.9 хувийг газраар, 12.1 хувийг агаараар, үлдсэн 50 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг тус тус эзэлж байна.

Монгол Улсад сэтгэцэд нөлөөт метамфетамин агууламжтай “мөс” гэх бодисын урсгал, нийлүүлэлт 2019 оныг хүртэл Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас нийлүүлэгдэж байсан бол 2019 оноос хойш Бүгд Найрамдах Турк Улсаас нийлүүлэх

явдал эрс нэмэгдсэн бөгөөд цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилийн хугацаанд хураан авсан синтетик төрлийн мансууруулах бодисын **75.8** хувийг БНТУ-аас хууль бусаар хил нэвтрүүлсэн гэмт хэрэг эзэлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис дараах урсгалаар манай улсад нийлүүлэгдэж байна. Үүнд**:** Бүгд Найрамдах Турк Улс нь Европ болон ойрх дорнод, Төв Ази хооронд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дамжин өнгөрүүлэх, хүлээн авах, илгээх зэрэгт газар зүйн байршлын хувьд онцлог бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд 8 сая экстази буюу мансууруулах үйлчилгээтэй шахмал бэлдмэлийг хураан авсан нь Европын Холбооны улсуудад хураан авсан энэ төрлийн мансууруулах бодисын хэмжээнээс давж гарсан.

Тус улс руу сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсын 19103 иргэн нэвтэрч, цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодистой холбоотой сэжигтэй этгээдийн бүртгэлийн “E-drug” санд бүртгэлтэй 24 хүн тухайн улс руу зорчсонд хяналт тавин ажиллаж байна.

Афганистан Улсаас сүүлийн үед метамфетаминыг маш хямд үнээр хар зах зээлд нийлүүлж, дэлхий дахинд энэ төрлийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэх, нийлүүлэх гэмт хэрэг огцом өсөж байгаа нь манай улс руу хөрш улсууд болон Турк улсаар дамжсан чиглэл маршрутаар нийлүүлэгдэж, цаашлаад Казкастан улсаар дамжиж болзошгүй байгаад анхаарах нь зүйтэй.

Сүүлийн 7 жилийн хугацаанд Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийн 37.9 хувийг газрын боомтоор нэвтрүүлсэн хэрэг, 12.1 хувийг агаарын

боомтоор нэвтрүүлсэн хэрэг, 50 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг тус тус эзэлж байна.[16]

Он/ Төрөл	Газрын боомтоор	Агаарын боомтоор	Шуудан илгээмжээр	Нийт
2017	11	-	2	13
2018	9	-	5	14
2019	5	-	13	18
2020	-	-	6	6
2021	-	-	5	5
2022	-	3	2	5
2023	-	5	-	5
2024	1	4	5	10
Нийт	**25**	**8**	**33**	**76**

Монгол Улсын байнгын болон түр ажиллагаатай боомтуудын нөхцөл байдалд хийсэн тандалт, судалгаагаар хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эрсдэл бүхий дараах боомтууд байна. Үүнд,

1. Сэлэнгэ аймгийн - Алтанбулаг, Сүхбаатар боомт,
2. Дорноговь аймгийн - Замын-Үүд боомт,
3. Буянт-Ухаа агаарын боомт,
4. Хөвсгөл аймгийн - Ханх боомт,
5. Баян-Өлгий аймгийн - Цагаан нуур боомт,
6. Өмнөговь аймгийн- Гашуун сухайт, Шивээхүрэн боомт,
7. Дорнод аймгийн - Хавирга, Баянхошуу, Эрээнцав, Ульхан боомт,
8. Увс аймгийн- Боршоо, Тэс боомт,
9. Ховд аймгийн- Байтаг, Булган боомтууд тус тус байна.

Мөн Орхон, Дархан-Уул аймгуудад мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна.

Сүүлийн 8 жилийн хугацаанд 419,2 мянган иргэний нэг удаагийн хэрэглэх бодис хураан авч, 46,3 тэрбум төгрөгийн хууль бус эргэлтийг таслан зогсоосноос өнгөрсөн 2024 онд 71,386 иргэний нэг удаагийн хэрэглэх бодис хураан авснаас 116,7 кг өвс, 2,3 кг мөс хураан авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Улсын хэмжээнд дээрх цаг хугацаанд хураан авсан бодисын 33.8 хувийг гадаад улсад лабораторийн болон гар аргаар боловсруулсан мансууруулах бодисыг улсын хилээр орж ирэх үед хураан авсан бол үлдсэн 66.2 хувь нь Монгол Улсад ургадаг олсны төрлийн буюу каннабисийн ургамал байна.

16 ЦЕГ-ын Гэмт хэргийн статистик тайлан 2017-2024 он.

Үүнээс дүгнэхэд нийт бүртгэгдэж байгаа гэмт хэргийн 30 орчим хувь нь улсын хилээр хууль бусаар орж ирж байгаа лабораторийн аргаар үйлдвэрлэдэг (Амфетамин, метамфетамин, ЛСД г.м) төрлүүд байгаа бол дийлэнх буюу 70 хувь нь манай улсад ургадаг олсны төрлийн буюу каннабис бодис байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл нь бие махбодод эмийн үйлчилгээ талаасаа хэрхэн нөлөөлж байгаагаар ангилан авч үздэг. Энэ тохиолдолд хяналттай бүх бодисууд 6 хэсэгт хуваагддаг. Үүнд:

1. Опиоид;
2. Каннабисаас гаргаж авсан хар тамхины бодис;
3. Өдөөгч, амфетамин;
4. Сэтгэцэд нөлөөт;
5. Тайвшруулах бэлдмэл болон транквилизатор;
6. Хяналтад байдаг бусад бодис гэх мэт.

Монгол Улсад ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)тай холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, тархцыг хумих, устгах зорилгоор тархац бүхий 14 аймгийн нутаг дэвсгэрт жил бүр “Устгал” нэгдсэн арга хэмжээг 2013 оноос хойш зохион байгуулсны үр дүнд давхардсан тоогоор 10,2 мянган га талбайд устгал хийж, Архангай, Ховд, Завхан аймгуудад устаж 11 аймаг болж буурсан. Мөн 2021 онд Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн хийсэн судалгаагаар тархац 5,000 га хүрч буурсан дүгнэлт гарсан.

Нийгэмд учирч буй аюул, хор уршиг:

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь Үндэсний аюулгүй байдал, хүн амын удмын сан, иргэдийн эрүүл мэнд, амь нас, эдийн засгийн бие даасан байдал, соёл иргэншил, язгуур ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, ахуйн хэрэглээний газ зэргээс шалтгаалж, 24 иргэний амь нас хохирсон тохиолдол бүртгэгдсэн.

Мансуурах зорилгоор судсаар тарьж зохисгүй хэрэглэх болсон тебантин, лидокайн зэрэг эмийг конвенцын жагсаалтад ороогүй учир эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй, үнэ хямд, олдоц элбэг, үйлчилгээ өндөр зэрэг шалтгааны улмаас хууль бусаар хэрэглэж, халдварт өвчин тархах, амь нас эрсдэх тохиолдол нэмэгдэж байна.

1.6 Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий этгээд болон далд хэрэглэгчдийн талаар

Дэлхий эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллагын хамтарсан судалгаагаар 15-64 насны 100 мянган хүн тутмын 2,700 хүн хэрэглэдэг.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан иргэдийн тоо, гэмт хэргийн өсөлт зэрэгт үндэслэн тархцын хурд тодорхойлох аргаар далд хэрэглэгчийн таамаглалыг тодорхойлбол 20 орчим иргэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай далд хэрэглэгчид байж болзошгүй байна.

Монгол Улсын 15-24 насны иргэдийн хүн амд тархалтын хувийг энэ төрлийн хэрэг, зөрчилд холбогдсон иргэдийн тоотой харьцуулбал жил бүр 0,1 хувиар өссөн дүнтэй байгаа нь бусад насны бүлгийн иргэдээс харьцангуй өндөр байна.

Монгол Улсын иргэд гадаад улсад болон гадаад улсын иргэд манай улсад ял шийтгэгдсэн байдал.

Монгол Улсад Нигер улсын 4, ОХУ-ын 2, БНСУ, Нидерланд, Англи, Энэтхэг, Турк, Хятад улсын тус бүр 1 иргэн нийт 8 улсын 12 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, 2 иргэн хорих ял шийтгэгдэж, эрүүгийн хариуцлага хүлээсэн байна.

Баруун Африкийн гэмт бүлэглэлд хамаарах Нигер Улсын этгээдүүдээс Монгол Улсын иргэдийг хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах, элсүүлэх, синтетик төрлийн мансууруулах бодисын урсгал, нийлүүлэлтийг нэмэгдүүлж байна.

Тухайлбал: Нигер Улсын 4 иргэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт 2019 онд шалгагдаж 2 иргэн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр орж 1 иргэн 3 жилийн хорих ял шийтгэгдэж хорих ялын хугацаа дуусаж суллагдсан.

Сүүлийн 8 жилийн байдлаар Монгол Улсын 113 иргэн гадаад улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, 84 иргэн хорих ял, 38 иргэн хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн.

Гадаад улсуудад 2024 оны байдлаар хар тамхи, мансууруулах бодистой холбоотой БНХАУ-д 37, ХБНГУ-д 2, БНТУ-д 3, Япон-д 1, БНСУ-д 1 нийт Монгол Улсын 44 иргэн хорих ял эдэлж байгаагаас 7-12 жилийн хорих ял шийтгэгдсэн 16, 15-20 жилийн хорих ял шийтгэгдсэн 13, хугацаагүй хорих ял шийтгэгдсэн 6, ялын хэмжээ тодорхойгүй 9 иргэн байна.

37 1 3 2 1

Хоёр: ГАДААД НӨХЦӨЛ БАЙДАЛ

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан мэдээлэлд 2024 онд дэлхийн хэмжээнд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 500,000 орчим гэмт хэрэг бүртгэгдэж, 1200 тонн орчим мансууруулах бодис хураагдсан байна.

Хамгийн их гэмт хэрэг бүртгэгдсэн улс орнуудыг жагсаалтаар харуулбал:

1. АНУ: Жилд ойролцоогоор 100,000 орчим хар тамхины гэмт хэрэг бүртгэгддэг ба олон улсад бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

2. Европын холбооны орнууд: Герман, Франц, Нидерланд зэрэг орнуудад жилд нийт 40,000 орчим хар тамхины гэмт хэрэг бүртгэгддэг.

3. Афганистан улс: Опиумын үйлдвэрлэлийн бууралттай холбоотойгоор гэмт хэргийн тоо буурсан боловч хар тамхины гэмт хэрэг 10,000 орчим бүртгэгдсэн байна.

4. Мексик улс: Жилд 50,000 орчим гэмт хэрэг бүртгэгддэг ба хар тамхи тээвэрлэлт, мафийн үйл ажиллагаа хамгийн том асуудал болдог.

5. Колумб улс: жилд 30,000 орчим гэмт хэрэг бүртгэгддэг. Дэлхийн Кокаин үйлдвэрлэлээр тэргүүлэгч улс тул ихэвчлэн хар тамхийг гадагшаа экспортолдог.

Дэлхийн томоохон үйлдвэрлэгч болон шинэ төрлийн мансууруулах бодис үйлдвэрлэгч орнууд: Дэлхийн улс орнууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хүчин чадавхаа нэмэгдүүлэхэд тууштай анхаарч, улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд хар тамхины хэрэглээ эрчимтэй нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх болсон.

Олон улсад Ковид цар тахал тархаж 2020 оноос улс орнууд хилээ хаасантай холбоотой энэ төрлийн гэмт хэрэг илүү нууц, далд хэлбэрт шилжиж, үндэстэн дамнасан зохион байгуулалттай хар тамхины гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжиж шуудан илгээмж болон усан замын боомтоор их хэмжээний хар тамхи нэвтрүүлэхийг завдсан хэрэг ихээр бүртгэгдсэн.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Хар-Тор буюу гэмт хэргийн цахим хар зах зээл болох Darkweb хаалттай сайтаас худалдан авах үйлдлүүд ихсэж, криптовалют ашиглан төлбөр тооцоо хийж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учирч, цахим орчны захидал харилцаанд мансууруулах бодисыг худалдан борлуулахад эможи буюу зурагт дүрсийг ашиглаж эхэлсэн.

НҮБ-ын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх албаны гаргасан 2021 оны тайланд дурдсанаар дэлхийд 15-64 насны 275 сая хэрэглэгч бүртгэгдэж, 2030 он хүртэл орлогын түвшин бага, хөгжил буурай болон хөгжиж буй улс орнуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч 43 хувиар, дундаж орлоготой улсуудад 10 хувиар тус тус өсөх хандлагатай талаар тайлагнасан.[17]

Мөн дэлхийн хэмжээнд амфетамин хэрэглэдэг нийт хүмүүсийн гуравны нэгээс илүү нь (9.9 сая хүн) азид байдаг. Ази тивд амфетамины төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ жил тутам өсөлттэй,[4] метамфетаминыг шахмал болон талст хэлбэрээр хэрэглэж байгааг онцолсон.[18]

---

17 НҮБ-ын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх хорооноос гаргасан Дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын 2021 оны тайлан. https://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/wdr2021.html [4] https://wdr.unodc.org/wdr2020/en/drug-use-health.html

18 Manop Kanato and others, eds., ASEAN Drug Monitoring Report 2018, 2nd ed. (Bangkok, ASEAN Narcotics Cooperation Centre, 2019).

Олон улсад шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис Тритамин, Нулимс MDMB-4enPINACA, фентанилын аналогууд, Гамма /Gamma Butyrolactone (GBL)/, синтетик каннабинойд /spice-K2/, кратом, синтетик марихуан[19] зэрэг нэршилтэй шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис дэлгэрсэн.

Хүн амын тооны байдлаар ОХУ, БНХАУ, Пакистан зэрэг улс орнуудын мансууруулах бодис хэрэглэгчдийг дэлхийн улс орнуудтай харьцуулахад мансууруулах бодисыг судсаар тарьж хэрэглэгчдийн 49 хувийг эзэлдэг.[20]

Түүнчлэн шинэ төрлийн мансууруулах бодисын зах зээл бий болсон улс орнуудын жагсаалтад манай орны хөршүүд болох ОХУ, БНХАУ орж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил тутам ихэссээр байна.

БНХАУ-ын хувьд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй хатуу тэмцэж байгаа боловч шинэ төрлийн мансууруулах бодисыг таньж мэдэх, тодорхойлоход хүндрэл учирч байна. Тус улсын Хар тамхитай тэмцэх газраас 2021 онд героин болон уламжлалт хар тамхины хурдацтай тархалтыг таслан зогсоосон бол харин синтетик ялангуяа метамфетамин, кетамин хэрэглэгчид хурдацтай нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо залуужиж, эмийн төрлүүд нэмэгдсэн.

Дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдалд үйлдвэрлэгч орнууд нь маш том асуудал болж хүндрүүлдэг. Нэгдсэн Үндэсний Байгууллагын судалгаагаар хамгийн том үйлдвэрлэгчид болон нөхцөл байдал хүндэрсэн дараах улс, орон байна[21]. Үүнд,

1. **Афкинистан** – Алтан хавирган сар
2. **Тайланд –** Алтан гурвалжин
3. **Мьянмар –** Алтан гурвалжин
4. **Лаос –** Алтан гурвалжин
5. **Боливи –** Латин Америк
6. **Бразил -** Латин Америк
7. **Колумб -** Латин Америк
8. **Мексик –** Латин Америк
9. **Доминик –** Карибын тэнгис
10. **Нигери –** Африк тив
11. **Филлипин –** Зүүн өмнөд ази
12. **Хятад –** Төв ази

Хар тамхины үйлдвэрлэгч улс орон болон бүс нутаг

19 https://wdr.unodc.org/wdr2020/en/exsum.html

20 НҮБ-ын Дэлхийн мансууруулах бодисын нөхцөл байдлын тайлан. 2020. Хоёрдугаар номын 39-р хуудас.

21 НҮБ-ын Хар тамхитай тэмцэх албаны 2023 онд шинэчлэн гаргасан улс орнуудын гэмт хэргийн хөдөлгөөний мэдээлэл.

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хар тамхины зах зээлд нөлөө бүхий үйлдвэрлэгч, худалдан борлуулагч улс, бүс нутгаар дараах улс, орнуудыг тодорхойлдог. Үүнд.



Алтан Хавирган сар гэх бүс нутагт: Иран, Афганистан, Пакистаны нурууны дунд оршдог Төв Азийн хамгийн том опиум үйлдвэрлэдэг бүс нутаг юм.

Алтан Гурвалжин гэх бүс нутагт: Мьянмар, Тайланд, Лаосыг холбосон бүс нь опиум тариалах, героин, метамфетамин үйлдвэрлэх, хар тамхины худалдаа, хар тамхины наймааны голлох бүс нутаг юм.

Мөн сүүлийн жилүүдэд олон улсын нөхцөл байдлыг тодорхойлоход “Хар гурвалжин”, “Мөнгөн гурвалжин” нэр томьёог ашигладаг. Эдгээр улс орнууд нь Америк тивийн Колумб, Боливиа, Бразил, Африк тивийн Нигери, Гана, Гвиней улсууд хар тамхины хууль бус эргэлтийн гол цэгүүдээр нэрлэгдэж байна.

Гадаад улс орны ялын бодлого. Энэ төрлийн гэмт хэрэгт оноож байгаа манай улсын ялын бодлого бусад орнуудаас хөнгөн, шүүхийн байгууллагаас шүүгч өөрийн эрх мэдлийн хүрээнд тус гэмт хэрэгт оноож байгаа ялын доод хэмжээ ихэвчлэн 1 жилийн хугацаатай хорих ялаар шийтгэж байгаа нь гэмт хэрэг гаралт нэмэгдэх, дахин гэмт хэрэгт холбогдох нэг шалтгаан нөхцөл болж байна.

Бусад улс орнууд нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, орон байраар хангах, завших, хууль бусаар тариалах зэрэг хэргийн үйлдэгдэж хэргийн төрөл, хураагдсан бодисын хэмжээ зэргээс шалтгаалан “Бүх насаар нь хорих”, “Цаазаар авах” хүртэлх ял шийтгэгдэж байгаа нь манай улстай харьцуулахад чанга, хатуу ялын бодлогыг баримталж байгаа нь харагдаж байна.

Монгол Улсад 2002 оны Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйл ангиар 497 иргэд, одоогийн эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт 1443 ял шийтгэгдэж, нийт 1940 хүн энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байна.

	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах
Монгол улс	1-5 жил хорих эсхүл зорчих эрх хязгаарлах	1-5 жил хорих эсхүл зорчих эрх хязгаарлах	1-5 жил хорих эсхүл зорчих эрх хязгаарлах	1-5 жил хорих эсхүл зорчих эрх хязгаарлах
	2-8 жил хорих	5-12 жил хорих		5-12 жил хорих
БНХАУ	Эд хөрөнгө хураж, 3-15 жил, бүх насаар нь хорих, цаазаар авах,			
ОХУ	40,000 рубль хүртэл торгох, 3-20 жил хүртэл хорих			
Сингапур улс	10,000$ торгох, 3-20 жил хүртэлх хугацаагаар хорих, Цаазаар авах			
Индонези улс	2-15 жил хорих, бүх насаар нь хорих, цаазаар авах			
БНЭУ	10,000 рупигээр торгох, 6 сар хорих, 200,000 рупигээр торгох, 5-20 жил хорих Давтан үйлдсэн тохиолдолд цаазаар авах			
Турк улс	2-5 жил	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг хүн, эмийн үйлдвэр холбогдвол ялыг 50 хувиар нэмэгдүүлнэ.	5-15 жил хорих 20,000 өдрийн хөдөлмөрийн хөлсөөр торгох	

Дээрх судалгаанаас харахад энэ төрлийн гэмт хэрэгт оноож байгаа манай улсын ялын бодлого нь бусад орнуудаас хамгийн бага, зөөлөн бодлого төрөөс барьж, шүүхийн байгууллагаас шүүгч өөрийн үзэмжээ тус гэмт хэрэгт оноож байгаа ялын хэмжээ ихэвчлэн 1 жилийн хугацаан хорих ялаар шийтгэж байгаа нь гэмт хэрэг гаралтад нөлөөлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт зах зээлийн хуулиар эрэлт нийлүүлтээс бүрддэг.

Эрэлт нь сонирхогч, хэрэглэгч, донтогч этгээдүүдээс бүрдэж байгаа бол нийлүүлэлт нь гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалж, гэмт бүлэглэл, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, сэжигтэй этгээдүүд, сэжигтэй байр байгууламжууд, худалдан борлуулагч, ургамлын тархац, эдийн засгийн сонирхол зэргээс бүрдэж байна.

Монгол Улс нь анх 1990-ээд оны үед олон улсад хар тамхи дамжин өнгөрүүлэгч орноор нэрлэгдэж байсан ба тухайн үед гэмт хэргийн гаралт маш бага байсан бол 2000-2020 онд гэмт хэргийн гаралт ихсэж, хэрэглэгч улс орнуудын нэг болсноор хэрэглэгчид, донтогчдын тоо нэмэгдэж, эрэлт, нийлүүлэлт нэмэгдсэн.

Харин 2020 оноос хойш сэжигтэй этгээдүүд нь ахуйн хүрээнд өвсний ургамлыг газтай хольж шавар, гашиш бодисыг гар аргаар гарган авч ашигласан хэргүүд

бүртгэгдэж эхэлсэн нь цаашид манай улс нь олон улсад үйлдвэрлэгч орон руу шилжих эрсдэл бий болсон.

Цаашид энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа манай улс руу чиглэж Мафия үүсэж, гадаадаас нийлүүлэгдэх хар тамхины урсгал нэмэгдэх, дотоодод мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус үйлдвэрлэлүүд бий болох чиг хандлагатай байна.



Нийлүүлэлт нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлүүдэд дараах хүчин зүйлээс нөлөөлж байна. Үүнд,

- Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлын тархац-хяналт,
- Энэ төрлийн гэмт хэрэгт оноож байгаа ялын бодлого сул,
- Гэмт этгээдүүд давтан гэмт хэрэг үйлдэх,
- Мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлах,
- Шинэ төрлийн мансууруулах бодисын эргэлт нэмэгдэх,
- Гэмт этгээдүүдийн хялбар аргаар мөнгө олох шунахай сэдэл,
- Хил гаалийн хяналт шалгалт сул байгаа зэрэгтэй холбоотой байна.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа сэжигтэй этгээдүүд нь дараах хууль бус үйлдлийн аргыг голчлон ашиглаж байна. Тухайлбал,

- Карго, шуудан илгээмж ашиглах, ачаа тээшинд нууж улсын хилээр нэвтрүүлэх,

- Худалдан борлуулахдаа тодорхой байршилд нуувч, тайник, лойкишин ашиглан бодисоо нуух,

- Гэмт хэргийн цахим сүлжээ буюу Даркнетийг ашиглах,

- Бусдын данс ашиглах, ойрын хүрээллийн хэрэглэгч, донтогч нарт гараас гарт дамжуулах зэрэг үйлдлийн аргуудыг ашиглаж гэмт хэргийг үйлдэж байна.

Хэрэглэгч, донтогч болох шалтгаан нөхцөлийн 67.8 хувь нь сониуч зан, бусдыг даган дуурайх, 43.2 хувь нь чөлөөт цаг ихтэй, 23.6 хувь нь хор уршиг, ойлголт мэдлэггүйгээс болж, 51 хувь нь буруу эх сурвалжаас авсан мэдээлэл, 41.5 хувь нь найз нөхөд танилын хүрээллээс болж эрэлт нэмэгдэж буй шалтгаан нөхцөл болж байна.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх гаалийн байгууллагын нөхцөл байдал.

Гаалийн байгууллага нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн заалт, Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 хэсгийн заалтын дагуу Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хилээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Мансууруулах эмийн тухай 1961 оны конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенц, “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийг тус тус мөрдлөг болгон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооноос гаргасан шийдвэр, зөвлөмжийн дагуу батлагдсан төлөвлөгөө, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Монгол Улсын Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын (ДГБ)-ын гишүүнээр 1991 онд илсэн орсон ба ДГБ-ын гишүүн 186 орны гаалийн байгууллагууд нь дэлхийн нийт худалдааны 98%-ийг хамарсан гаалийн хяналтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээр улс орнуудын дөрөвний гурав нь хөгжиж байгаа улс орнууд байна. Дэлхийн Гаалийн Байгууллагын дэргэд үндсэн гурван салбар байгууллага ажилдаг ба үүний нэг чухал салбар байгууллага болох Зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх бүс нутгийн төв буюу (Regional Intelligence Liaison Office / RILO) нь ДГБ-ын нийт гишүүн орны гаалийн байгууллагуудыг бүс нутгаас

хамаарч 6 хэсэгт хуваадаг ба манай улсын хувьд Ази, Номхон далайн Зөрчлийн мэдээлэл солилцох төв болох (Regional Intelligence Liaison Office Asia/Pacific) харьяалагдан нэг бүсэд хамаарч буй улс орнуудын гаалийн байгууллагуудтай мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр нягт хамтран ажиллаж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага

Манай улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, хууль бус эргэлтийн цар хүрээ улам томорсоор байгааг Нэгдсэн Үндэсний Байгууллагын тандалт судалгааны тайлан, дотоодод илэрсэн болон улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт үйлдлийн тоон мэдээлэл статистикаас харж болохоор байна.

Гаалийн байгууллагын 2018-2024 онд илрүүлсэн гэмт хэргийн нөхцөл байдлаас харахад сүүлийн жилүүдэд бага тунгаар өндөр үйлчилгээ үзүүлдэг, “хар зах” дээр өндөр үнэлгээтэй шинэ төрлийн синтетик мансууруулах бодисыг бага хэмжээгээр олон давтамжтайгаар хилээр нэвтрүүлэх байдал ажиглагдаж байна. Бага хэмжээтэй мансууруулах бодисыг бусад эд зүйлсийг нуувч болгон ашиглаж илгээх нь гаалийн хяналт шалгалтаар илрэхгүй байх өндөр магадлалтай тул гэмт этгээдүүд энэхүү аргыг ашиглаж мансууруулах бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх оролдлого нэмэгдэж байна.

Гаалийн байгууллагын 2018-2024 оны хооронд илрүүлсэн гэмт хэргийг оноор нь ангилж үзвэл жилд дунджаар 17 хэрэг илрүүлсэн байх боловч 2019-2021 оны хоорондох үзүүлэлт дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа зогссон, улс хоорондын шуудан илгээмж хязгаарлалттай байсантай холбоотой юм.



График-1. 2018-2024 онд илрүүлсэн хэргийг он тус бүрээр харьцуулбал

Гаалийн байгууллагын илрүүлсэн 2018-2024 онд илрүүлсэн зөрчлийг гаалийн газар хороогоор ангилж үзэхэд нийт 82 удаагийн үйлдлийн 60 нь буюу 73 хувь нь

олон улсын шуудан илгээмжийг ашиглан мансууруулах бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан байна.

График-2. 2018-2024 онд илрүүлсэн хэргийг гаалийн газар хороогоор харьцуулсан байдал.



Олон Улсад шуудан илгээмжийг ашиглах нь эрсдэл багатай, цаг хугацаа хэмнэж, тухайн барааны илгээгчийн байршлыг төөрөгдүүлэх, газар зүйн байршлаас үл хамаарч хүссэн бүс нутгаас захиалга хийх зэргийг давуу тал болгон ашиглаж байгаа бол манай улсын хувьд ч дээрх зүйлсийг давуу тал болгохоос гадна бусдын бичиг баримтыг ашиглаж өөр хүний нэрээр захиалга хийх, хүлээн авагчийн нэр, хаягийн мэдээлэлгүй ирүүлэх зэргээр тухайн гэмт этгээд өөрийгөө эрсдэлд оруулахгүйгээр хууль бус бараа, эд зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зорилгоор ашиглаж байна.

Илгээгч улс	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
АНУ	2	1	1	2	9	4	2	**22**
ХБНГУ	2	2		1		1	2	**8**
Нидерланд	7	1				1	3	**12**
Их британи	3		1		1	1	2	**8**
Испани	1	1						**2**
Тайланд		1					1	**2**
Малави				1				**1**
Сингапур					3	2		**5**
АНЭУ						1		**1**
Мексик							1	**1**
ОХУ							1	**1**
Вьетнам					1	3		**4**
Малайз					1		2	**3**
БНТУ						5	3	**8**
БНХАУ	1					1		**2**
БНСУ					1			**1**
Киргизстан	1							**1**

Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисуудын илгээгч улсын мэдээллийг авч үзэхэд АНУ, ХБНГУ, Нидерланд, Их британи, Турк зэрэг европын улсууд байх ба 2019 онд гарсан Ковид-19 цар тахлаас хойш зүүн өмнөд азийн улсуудаас түгээмэл нийлүүлэгдэж байна. Мөн Баруун Африкийн гэмт бүлэглэлээс Монгол улс руу метамфетамин бодисыг их хэмжээгээр олон улсын шуудан илгээмжээр хэлбэр дүрсийг өөрчлөх, бараа, эд зүйлийг нуувч болгон ашиглаж илгээх тохиолдол тасралтгүй гарсаар байна.

Гэмт хэргийн шинжтэй үйлдлийн ихэнх хувийг эзэлж буй илгээгч улсаар авч үзвэл АНУ-22 удаа буюу нийт зөрчлийн 37 хувь ,ХБНГУ-8 буюу 10 хувь, Нидерланд-12 буюу 15, Турк-8 удаа буюу 10 хувь, Их Британи 8 удаа буюу 10 хувийг тус тус эзэлж байна.

2018-2024 оны хооронд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэрэгт нийт 82 иргэн холбогдсон ба тус гэмт хэрэгт холбогдогчдыг иргэний харьяаллаар авч үзэхэд 77 удаагийн үйлдэл буюу 97 хувийг манай улсын иргэд, 2 удаагийн үйлдэлд буюу 3 хувьд нь гадаадын иргэд холбогдсон байх ба 81 удаагийн үйлдэл нь улсын хилээр орох чиглэлд 1 удаагийн үйлдэл нь гарах чиглэлд үйлдэгдсэн байна. Энэ судалгаанаас харахад улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан нийт 82 зөрчлийн 81 нь орох чиглэлд үйлдэгдсэн байх тул манай улс нь дамжуулагч бус хэрэглэгч орон болж байгаа гэх НҮБ-ын судалгааг бататгаж байна.





Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр тусгайлсан чиг үүрэг бүхий Тагнуул, Цагдаа, Гаалийн байгууллагууд Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд нэгдсэн нэг зорилгын төлөө нягт хамтран ажиллаж байна. Манай улсын хувьд хоруу чанар өндөртэй синтетик төрлийн мансууруулах бодисыг дотооддоо үйлдвэрлэгч бус бусад улс орноос импортлогч статустай орон тул улсын хилээр нэвтрүүлэх үед нь таслан зогсоох нь цаг хугацаа, хүн хүч, зардал мөнгөний хувьд хэмнэлт гаргах, нийтэд хүртээх эрсдэлийг бууруулах давуу талтай гэх ойлголтод санал нэгдэн хамтран ажиллаж байна.

Гаалийн байгууллага энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийг таслан зогсоох, эцсийн хүлээн авагч, холбогдогчийг тогтоох, саатуулах зэрэгт ач холбогдол бүхий хуулийн заалтыг “Гаалийн тухай хууль”-ийн 250 дугаар зүйлд тусгаж өгсөн байдаг ба энэ заалт нь хэрэгжилтийн хувьд гэмт хэрэг үйлдэгчдийн тээвэрлэх арга барилаас хамаарч төдийлөн хангалттай хэрэгжихгүй байсан ч өнөөгийн цаг үед буюу олон улсын шуудан илгээмжийн үйлчилгээг ашиглан гэмт хэрэг үйлдэж буй нөхцөлд маш үр дүнтэй хэрэгжиж байна.

Гаалийн тухай хуулийн 250.1-т “Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг бараг гаалийн хяналтын дор хүргэх аргыг хэрэглэж болно.” гэж заасан байх ба уг заалтыг хэрэгжүүлэх журам боловсруулах шаардлагатай хэдий ч дээр

дурдсанчлан өнөөг хүртэл энэ хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байсантай холбоотой журам боловсруулагдаж батлагдаагүй болов ч Цагдаа, Тагнуул, Гаалийн байгууллага энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд ач холбогдол бүхий уг заалтын хүрээнд хамтран ажилласаар байна.

Гаалийн байгууллагын санаачилгаар 2023 онд Улсын хилээр дээрх хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр Тагнуулын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Хориглосон, хязгаарласан барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийгдэх “Суваг 1” хамтарсан арга хэмжээний удирдамжийн батлан ажилласан ба тухайн арга хамтарсан арга хэмжээ нь маш үр дүнтэй болж богинохон хугацаанд их хэмжээний улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан барааг илрүүлж ажилласан.

Алба хаагчдын чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх, хамтарсан арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт илрүүлэлт нэмэгдэх, эцсийн хүлээн авагч, холбогдогч нарыг олж тогтоох, саатуулах ажиллагаа амжилттай үр дүнтэй хэрэгжих юм.

ТАВ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ЭРХ ЗҮЙ ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор тодорхой хууль эрх зүйн орчин, мэргэжлийн байгууллагын бүтэц бүрдүүлсэн боловч хэрэгжилтийн шатанд хэд хэдэн ноцтой бэрхшээл, саад тулгарсаар байна. Эдгээр асуудлуудыг цогцоор нь тодорхойлон авч үзвэл дараах байдалтай байна:

1. Хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байдал

Одоогийн мөрдөгдөж буй хуулиуд нь уламжлалт мансууруулах бодисын төрлүүдийг хамарч байгаа хэдий ч шинээр бий болж буй синтетик бодисуудын нэр төрөл, тэдгээрийн найрлага, үйлчлэл зэргийг ялган таних эрх зүйн тодорхойлолт тодорхой бус, ялгамжлал сул хэвээр байна. Үүний улмаас мөрдөн шалгах ажиллагаанд бэрхшээл үүсэж, зарим төрлийн сэтгэцэд нөлөөлөх шинэ бодисыг “хуульд заасан” бодис биш хэмээн гүтгэлэг, хууль зөрчсөн үйлдлийг ял шийтгэлгүй өнгөрөх тохиолдол гарч байна. Энэ нь хууль сахиулах байгууллагын ажилд сөрөг нөлөө үзүүлж, гэмт хэрэгтнүүдэд ашигтай нөхцөл бүрдүүлдэг.

2. Техник, технологийн дутагдал

Хар тамхи болон сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх, тээвэрлэлтийн хэлбэр, орчин үеийн далд аргуудыг илрүүлэхэд шаардлагатай өндөр мэдрэмжтэй төхөөрөмж, хяналтын системүүд дутмаг байна. Ялангуяа хил, гааль дээр сэжигтэй тээвэрлэлт, шуудангийн илгээмж, цахим худалдааны сувгаар орж ирж буй бодисыг илрүүлэх шинэлэг техник хэрэгсэл, программ хангамжийн хомсдол нь хууль бус эргэлтийг зогсооход саад болж байна.

3. Мэдээлэл солилцооны хүндрэл

Цагдаагийн байгууллага, гааль, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, мэргэжлийн хяналт гэх мэт байгууллагууд хоорондоо шуурхай, үр дүнтэй, нэгдсэн мэдээллийн тогтолцоо бүрдүүлж чадаагүй хэвээр байна. Мэдээлэл дамжуулах, нягтлан шалгах үйл явц удаан, хүн төвтэй хэвээр байгаа нь мэдээллийн алдагдал, давхардал, цаг алдалт үүсэхэд хүргэдэг. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнг бууруулах нэг шалтгаан болдог.

4. Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх нь өндөр мэдлэг, нарийн мэргэшил шаарддаг салбар боловч тухайн чиглэлээр бэлтгэгдсэн тусгайлсан мөрдөгч, хими-биологийн шинжээч, кибер гэмт хэрэг судлаач зэрэг мэргэжилтнүүдийн тоо хангалтгүй байна. Мөн тогтвортой, үр дүнтэй сургалт,

мэргэшүүлэх хөтөлбөрүүд хангалттай хэмжээнд зохион байгуулагддаггүй нь хүний нөөцийн чадавхид шууд сөргөөр нөлөөлж байна.

5. Залуучуудын дунд урьдчилан сэргийлэх ажлын сул байдал

Мансууруулах бодисын хэрэглээ нь ихэвчлэн өсвөр үе, залуусын дунд тархах хандлагатай тул энэ бүлгийн хүмүүст чиглэсэн урьдчилан сэргийлэх боловсролын ажил нэн чухал. Гэвч боловсролын байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдлэг, ойлголт олгох сургалт, нөлөөллийн ажил тогтмол бус, хүрээ хязгаар нь хэтэрхий нарийн байдаг. Залуус цахим орчноос мэдээлэл авах хандлагатай байхад төрийн зүгээс баталгаатай, ойлгомжтой, сэтгэлзүйн нөлөөтэй контентууд хүргэх ажил сул хэвээр байна.

ЗУРГАА. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Олон улсын түвшинд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хяналт тавих системийг анх 1909 онд Шанхай хотноо Опиумын Комисс хэмээх нэрийн дор хуралдсан үеэс бий болсон гэж үздэг. Уг хуралд 13 орон оролцож олон улсын гэрээ, хэлэлцээрийг үзэглэж байсан бол 1912 онд Гааг хотноо зохиогдсон хар тамхины талаарх олон улсын бага хурлаас эмийн зүйлд хяналт тавих тухай олон улсын гэрээ батлагдсан[22] зэргээс энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх олон улсын эрх зүйн баримт бичгүүд ээлж дараалан бий болжээ.

Үүний дараагаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр чухал ач холбогдолтой баримт бичиг нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг баталсан явдал юм. Тодруулбал, НҮБ-ын 81 улс орон оролцон “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”[23], мөн 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсан протокол[24], “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенц[25] 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Вена хотноо 71 орны төлөөлөгчид оролцон баталж байсан зэргийг дурдаж болох юм.

Мөн өөр нэгэн чухал баримт бичиг бол “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц”-г 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж байсан[26]. Эдгээр нь олон улсын түвшинд төдийгүй, үндэсний хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал эх сурвалж юм.

Манай хойд хөрш ОХУ-д 18 сая хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч байна гэсэн судалгаа байдаг бол үүнээс жилд 500,000 донтогч сайн дурааараа мэргэжлийн эмнэлгийн байгууллагад хандаж, 50,000 нь эмчилгээгээ бүрэн хийлгэдэг. Харин хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч дундаас 1 жилд 70,000 хүн буюу 1 өдөрт дунджаар 192 хүн нас бардаг гэсэн судалгаа байдаг.

Харин манай урд хөрш БНХАУ-д 2 345 000 хүн хар тамхи, мансууруулах бодисын хамааралтай болсон гэж албан ёсны бүртгэлтэй жилд дунджаар 243,000 мансуурагч, донтогч нэмэгддэг гэсэн тоо баримт байдаг байна. Бүртгэгдсэн донтогч нарын 1,465,000 нь 35-аас доош насны, 870,000 нь 36-59 насны, 11,000 нь 60-аас дээш насныхан гэсэн судалгаа байдаг бөгөөд тэдний эрчүүд нь эмэгтэйчүүдээсээ 6

---

[22] The United Nations and Drug Abuse control. 2 N, UN, 1989, p.63-64

[23] UN United Convention on narcotic drugs, 1961- Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон. (1961 оны 3 дугаар сарын 25-ний өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13 ний өдөр хүчин төгөлдөр болсон)

[24] Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон. төрийн мэдээлэл тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 957-996 дахь тал.

[25] Энэ конвенцыг Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан.

[26] Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон. “Төрийн мэдээлэл” тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 1033-1063 дах тал.

дахин их гэсэн тоон үзүүлэлт байна. Мөн судалгаагаар 18 нас хүрээгүй бага насны 43,000 хэрэглэгч 2014 онд бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 25,000 хэрэглэгчээр илүү бүртгэгдсэн байна. Тэдний дундаас хамгийн бага нь 11 настай хүүхэд байсан байгаа зэрэг судалгаанаас үзэхэд манай улсад хар тамхины аюул маш ойрхон аюулын харанга дэлдэж байна[27].

Дэлхийн хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдлын талаар жил бүр зохион байгуулагддаг Олон улсын хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 24- 30-ны өдрүүдэд АНУ-ын Хар тамхитай тэмцэх алба, Бүгд Найрамдах Перу Улсын Үндэсний цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан бөгөөд энэ удаа “Үндэстэн дамнасан хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаахтай тэмцэх асуудал нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох нь” сэдвээр ээлжит 33 дугаар хурал болж өнгөрсөн.

Уг хуралд дэлхийн 127 орны цагдаагийн болон хар тамхитай тэмцэх албаны 535 алба хаагч өөрсдийн орныг төлөөлөн оролцож өөрийн орны хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, хар тамхи тариалагч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, тээвэрлэгч гэмт бүлэглэл, синдикат, картелуудтай хийж буй тэмцэл, үр дүн, 2016-2017 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хувьсал өөрчлөлт, шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын талаар мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагааны туршлага солилцох зэрэг боломж олгосон уулзалт арга хэмжээг зохион байгуулж олон улсад хар тамхитай тэмцэх чиглэлээр үүрэг гүйцэтгэдэг албадын хамтын ажиллагааг бэхжүүлсэн хурал болсон байна. Хурлын тайланд дурдагдаж буйгаар 2015-2016 оны тайлант хугацаанд дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж буй хар тамхитай тэмцэх албад нь Өмнөд Америкийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй гэмт бүлэглэлд 5 удаагийн томоохон цохилт өгч 69 тонн кокайн, 80 орчим тонн каннабисын ургамлыг хураасан, Европ, Африк, Хойд Америк, Азийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэлүүдэд мөн давхардсан тоогоор 30 орчим цохилт өгөх арга хэмжээ зохион байгуулж үр дүнтэй ажилласан байна.

Монгол Улсын талаар хийсэн үнэлгээнд геройн, амфетамин, каннабис, экстазийн төрлийн мансууруулах бодисын хэрэглээ өсөлттэй, тархцын хувьд каннабис хамгийн их, намуугийн тархалттай, экстазийн урсгал БНХАУ-аас чиглэсэн, геройн, амфетамины төрлийн бодисын худалдааны замууд дайран өнгөрч байна гэж дүгнэгдсэн байна[28].

Манай улсын хар тамхи, мансууруулах бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт, хэрэглэгч нарын тоо бусад дэлхийн улс орныхтой

---

[27] Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал. Судалгааны ажлын тайлан. Уб.,2016. 14 дэх тал.

[28] Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал. Судалгааны ажлын тайлан. Уб.,2016. 20 дах тал.

харьцуулахад бага, их хэмжээгээр зөрүүтэй харагдаж байгаа хэдий ч улсын хүн амын тоо, хөрш залгаа улс орнуудын хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчийн тоо, тэдэнтэй тэмцэх аргачлал зэргийг харьцуулахад өнөөдрийн байдлаар манай улсад уг цагаан тахал гэгч зүйл хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд аюул авчрахуйц нөхцөл байдал үүссэн байна.

Эдгээр тоон мэдээллээс үзэхэд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, тархац асар хурдтай өсөн нэмэгдэж байгааг харж болох юм.

Үндэсний хэмжээнд энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх болон хар тамхитай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулах чиглэлийн дараах хууль тогтоомж хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль 2002 он,

2. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) 2017 он,

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 он,

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2017 оны 77 дугаартай тогтоол,

5. Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай -Засгийн газрын 2022 оны 247 дугаар тогтоол,

6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллах журам- Засгийн газрын 2010 оны 277 дугаар тогтоол,

7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай- Засгийн газрын 2003 оны 196 дугаартай тогтоол,

8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журам,

9. Жагсаалт батлах тухай /Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт/ - Байгаль орчны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 1998 оны 139/А/148,

10. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам- Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал,

11. Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж тогтоох журам- Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2016 он А/138,А/131 дугаар хамтарсан тушаал,

12. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай- Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаартай тушаал[29] зэрэг байна.

Харин дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг, мөн энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий тогтолцоонд дараах байгууллагууд хамаарч байна гэж үзэв. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл,

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хороо,

3. ХЗДХЯ-Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл,

4. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар,

5. Тагнуулын Ерөнхий газар,

6. Гаалийн ерөнхий газар,

7. Хил хамгаалах ерөнхий газар,

8. Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн,

9. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв,

10. Боловсрол, эрүүл мэндийн салбарын яам дах дэд салбар зөвлөлүүд,

11. УЕП г.м байгууллагууд хамаарч байна.

Тооны хувьд олон мэт боловч байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийхэд тийм биш аж. Учир нь эдгээр байгууллагууд нь бүгд тус тусдаа чиг үүрэгтэйгээс гадна, тус тусдаа удирдлагын тогтолцоотой юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас бусад байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаардаггүй нь энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.

Бусад байгууллагын тухайд зөвхөн дэмжлэг үзүүлэх байдлаар оролцож байгаа нь үндэсний тогтолцооны оновчтой бус байдлыг илэрхийлнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал нь дан ганц цагдаагийн байгууллагын үүрэг биш төдийгүй бусад байгууллагуудын нягт хамтын ажиллагааны үр дүнд энэ төрлийн гэмт хэргийг бууруулж чадна.

---

[29] Цахим эх сурвалж: Legalinfo.mn хандсан: 2025.04.10

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны хувьд үндэсний хэмжээний тэмцэх бодлогыг тодорхойлж, салбарын байгууллагуудад чиглэл өгч биелэлтийг хангах байдлаар ажилладаг. Харин биелэлтийг хангасан эсэх нь тодорхой байгууллагуудад хууль зүйн хариуцлага хүлээлгэх нөхцөл болдоггүй нь салбарын байгууллагуудын идэвхийг саармагжуулдаг байна.

Үндэсний хорооны дэргэд ажлын албатай байх бөгөөд энэхүү ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хариуцах зохицуулалттай. Зөвлөлийн даргаар Хууль зүй, дотоод хэргийн сайд ажилладаг тул энэхүү асуудал нь дан ганц Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяалах асуудал мэт нөхцөл байдал хэдийн үүсжээ. Тодруулбал, дагнасан чиг үүргийн байгууллага байдаггүй нь нэгдсэн тогтолцоог уялдуулж, удирдан зохион байгуулж чадахгүй байдалд байна.

Үндэсний хороо нь үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажил арга хэмжээний биелэлт хянахаас гадна ажлын албадаар дамжуулан бүхий л төрийн байгууллагын оролцоо бүхий мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдалтай тэмцэх жилийн төлөвлөгөөг боловсруулж хүргүүлдэг.

Энэхүү төлөвлөгөөнд заагдсан ажил арга хэмжээг хариуцсан байгууллагууд биелэлт тооцуулах хандлагаар хийж гүйцэтгэдэг нь төлөвлөгөөнд заагдсан ажлыг үр ашиггүй болгоход хүргэдэг байна.

Тагнуулын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илрүүлсэн улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон зарим тохиолдолд цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцож ажилладаг.

Энэ төрлийн гэмт хэргийг биетээр улсын хилээр тээвэрлэж гаргах нь илүү эрсдэлтэй болсон тул олон улсын шуудан тээврийг ашиглах болсон нь бүртгэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлаар илэрхийлэгдэж байна. Энэхүү аргаар үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхийн тулд илгээгч улсын хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага үүсдэг ч цаг хугацааны болоод эрх зүйн зохицуулалтын хувьд хангалттай байж чадахгүй байна.

Мөн гаалийн байгууллагын тухайд зөвхөн олон улсын шуудангаар ирүүлсэн сэжиг бүхий илгээмжид шалгалтыг хийж илэрсэн зөрчилд Хар тамхитай тэмцэх газарт мэдээлэх байдлаар чиг үүрэг хэрэгжүүлдэг. Энэ нь энэ төрлийн гэмт хэрэгтэй глобал түвшинд тэмцэхэд хангалтгүй хэвээр байна. Иймд энэ аргаар үйлдэгдсэн тохиолдолд илгээгч улстай бие даан холбогдож, шаардлагатай мэдээллийг цуглуулж хэвших нь мөрдөн шалгах ажиллагаанд эерэг үр дүнтэй.

Гаалийн байгууллага нь тусгай чиг үүргийн байгууллагын хувьд бусад орны ижил төрлийн байгууллагатай холбогдож шуурхай арга хэмжээ авах эрмэлзэл болоод эрх зүйн боломж хэрэгтэй байна.

Хар тамхи, сэтгэцэд нөлөөд бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн ард ямагт хэрэглэгч, донтогчийн асуудлыг орхигдуулж болохгүй. Аливаа эдийн засгийн шинжтэй гэмт явдалд зах зээл бодитой оршиж байгаа учраас л улам өсөн нэмэгдэж байдаг. Мөн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх нь өөрсдөө хэрэглэгч байдаг тул шүүхээр ял шийтгүүлсэн ч тодорхой хугацааны дараа дахин хэрэглэх явдал цөөнгүй байсаар байна.

Энэ тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний байгууллагуудтай нягт уялдаа, холбоотой ажиллах хэрэгцээ шаардлага үүсдэг. Гэтэл сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний байгууллагын тухайд зөвхөн шүүхээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдсэн хүмүүсийн хүлээн авах хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа нь учир дутагдалтай байсаар байна.

Мөн гэмт хэрэг шалгах явцад холбогдогч этгээдэд хэрэглэгч, донтогчийн шинж тэмдэг байгаа эсэхийг тогтоох шинжилгээг Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг бүрд хийлгэж хэвших шаардлагатай. Учир нь зөвхөн хэл ярианы хувьд хэвийн бус буюу илэрхий хэв шинжид шинжээч томилох байдал нь сэтгэцийн хувьд эмгэгтэй болсон зорилтод бүлгийг олж илрүүлэх, тогтооход учир дутагдалтай.

Энэ төрлийн гэмт хэргийн учир шалгаан, суурь нөхцөл нь мансуурах сонирхлоос үүдэлтэй бөгөөд сургуулийн насны хүүхдүүдийг архи, тамхи, хэрэглээний газ, цавуу зэрэг мансууруулах үйлчлэл бүхий эд зүйлсийг хэрэглэх сонирхлыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын байгууллагуудын хүчин чармайлт туйлын их шаарддаг. Ерөнхий боловсролын байгууллага нь харьяа цагдаагийн байгууллагатай хамтран хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтуудыг сэтгэхүйн онцлогт тохирсон агуулгаар боловсруулж байнга сургуулийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх нь үр дүнтэй байдаг.

Дээрх байгууллагуудын уялдаа холбоо нь зөвхөн харьяалах асуудлаар тохиолдолд бий болсон үед л идэвхэждэг онцлогтой байдал нь тус тусын чиг үүргийг ач холбогдолтой түвшинд хүргэж чадахгүй байна.

Дэлхийн нийтэд аюул заналхийлэл үүсгэж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт явдалтай тэмцэхийн тулд хэрэг үлдэгдсэний дараа мөрдөн шалгах чиглэлээр дагнасан байгууллагаас гадна, урьдчилан сэргийлэх, мэдээлэл нэгтгэн боловсруулах зэрэг институтийн хэмжээнд нэгдсэн удирдлага зохион байгуулалт шаардлагатай байна. Энэ талаар ч өмнө хийсэн судалгааны дүгнэлтэд дурдаж байв. Тухайлбал, “Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоо байхгүй байна”[30].

[30] Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал. Судалгааны ажлын тайлан. Уб.,2016. 23 дах тал.

Долоо. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн статистикт хийсэн дүн шинжилгээ

НАЙМ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улсын ерөнхий прокурорын газраас хийсэн судалгаагаар 2021 оноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар шүүхээр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, завших, хэрэглэх орон байраар хангах, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдал, шүүхээс оногдуулсан ял, улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын дүгнэлт”-ийг харьцуулсан судалгаагаар дээрх хугацаанд нийт 423 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байгаагаас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 8 шүүгдэгч, 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар 6 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.[31]

Сүүлийн 8 жилийн хугацаанд Монгол Улсын хилээр хууль бусаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрүүлсэн 76 гэмт хэргийн 37.9 хувийг газраар, 12.1 хувийг агаараар, үлдсэн 50 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг тус тус эзэлж байна.[32]

Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийг анхан шатны шүүхээс хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн хэргийг авч үзвэл:

1. Эрүүгийн 2102004860344 дугаартай хэрэгт Монгол Улсын иргэн нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц”-ын 2 дугаар жагсаалтад багтсан метамфетамины агууламж бүхий 27.788 грамм “мөс” гэх нэршилтэй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдаалах зорилгоор 2021 оны 9 дүгээр сард Бүгд Найрамдах Турк Улсын Станбул хотоос хууль бусаар олж авч, 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь хилийн шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн.

Харин Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хэргийг хүлээн авч хянан хэлэлцээд 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 2024/шцт/330 дугаартай шийтгэх тогтоолоор “Гадаад паспортод үзлэг хийсэн тухай “...10 дугаар хуудсанд Турк Улс руу 21.08.24-нд орсон, 21.10.06-нд гарсан штамб дарагдсан. 32 дугаар хуудсанд Монгол Улсын хилээр 2021.08.23-нд гарсан, 2021.10.06-нд буцаж

---

[31] УЕПГ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11 дугаартай зөвлөмж

[32] https://ubn.mn/p/78318 / ГЕГ-аас 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдөр “Улс хоорондын шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийх уулзалт”-ын үеэр хийсэн мэдээлэл/

орсон талаар тэмдэглэгээ тэмдэглэгдсэн...” гэх тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлт (1-р хавтаст хэргийн 98-99 дэх тал), Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрчээр “...2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын хилээр орж ирэхдээ 40 гаран грамм мөсийг өөрийн хувцас хийдэг хар өнгийн чемоданы дотор талын доод хэсгийн цахилгаантай хэсэгт нь хийж цахилгаанаа татаад дээрээс нь хувцсаа хийгээд Монгол Улсын хилээр орж ирсэн юм...” гэсэн мэдүүлэг (1-р хавтаст хэргийн 125-126 дахь тал)-д авагджээ.

Эдгээр баримтууд нь Х-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад заасан “хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн” гэх гэмт хэрэгт холбогдуулан шалгах үндэслэлийг бий болгожээ.

Мөрдөгч, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж буй прокурор нь гэмт хэргийн талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг зөвхөн хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр шалгаж тогтоох үүрэгтэй бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлах, хуульд заасан журмыг зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцож болохгүй юм.

Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэхийг урьдчилан сануулж, түүнээс гэрчийн мэдүүлэг авах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадгаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “...өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно...” гэсэн заалтыг зөрчих тул шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд зааснаар тухайн мэдүүлгийг нотлох баримтаар тооцож, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоогүй болно.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокуророос шүүгдэгч Х-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус журамлан мөн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болгон хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ” гэж дүгнэж хэргийг хөнгөрүүлэн зүйлчилж 6 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэжээ.[33]

[33] https://shuukh.mn/single_case/103091

Уг шийдвэрийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 сарын 02 өдрийн 2024/ДШМ/763 магадлалаар хэвээр үлдээсэн байна.[34]

[34] https://shuukh.mn/single_case/20420

ЕС. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2015 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар зүйлчилсэн 22 хэргийг анхан шатны шүүхээр хянан хэлэлцсэн байна.[35]

Тодруулбал, 2020 онд 1 хэрэг, 2021 онд 1 хэрэг, 2022 онд 6 хэрэг, 2023 онд 7 хэрэг, 2024 онд 5 хэрэг, 2025 онд 2 хэргийг анхан шатны шүүхээр хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээс 38 хүнд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдсэн 22 хэргийг хянан хэлэлцэхдээ 2 хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болгон хөнгөрүүлэн зүйлчилж, 1 хэргийг цагаатгаж шийдвэрлэсэн байна.

2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн судалгааг авч үзвэл:

2014 онд 7 хэрэг шийтгэгдсэн, 2015 онд 6 хэрэг шийтгэгдсэн, 2016 онд 7 хэрэг шийтгэгдсэн, 2017 онд 5 хэрэг шийтгэгдсэн, 2018 онд 11 хэрэг шийтгэгдсэн, 2019 онд 6 хэрэг шийтгэгдсэн, 2020 онд 8 хэрэг шийтгэгдсэн, 2021 онд 9 хэрэг шийтгэгдсэн, 2022 онд 9 хэрэг шийтгэгдсэн, 2023 онд 4 хэрэг шийтгэгдсэн, 2024 онд 9 хэрэг шийтгэгдсэн[36] байна.

Зураг 2. Шүүхээр шийдвэрлэсэн байдлыг графикаар харуулбал:

[35] Shuukh.mn/cases
[36] Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/

Сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2014-2024 он хүртэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах зүйл ангиар Монгол Улсын Эрүүгийн анхан шатны, давж заалдах шатны, хяналтын шатны шүүхээр нийт 81 гэмт хэрэг шийтгэгджээ.

Дээрх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг сүүлийн 10 жилийн хугацаанд 100 шалгагдаж, үүнээс 81 гэмт хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн нь шийдвэрлэлт 81 хувьтай байна.

Шүүгдэгч Н нь өөрийн найз болох У-ын Бүгд Найрамдах Турк улсаас явуулсан илгээмж болох Нэгдсэн Үндэстний байгууллагын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-ийн 2 дугаар жагсаалтад багтсан “Метанфетамин” бодисын агууламжтай, “Мөс” гэх нэршилтэй цэвэр жин нь 9,020 грамм хэмжээтэй хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 16 цагийн үед хорооны нутаг дэвсгэрт орших дэлгүүрийн гадаа А-той уулзан, түүгээр дамжуулан худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, мөн өдрөө тухайн бодисоо хорооны нутаг дэвсгэрт орших хорооллын 84 дүгээр 00 тоотод байх гэртээ болон өөрийн биедээ худалдаалах зорилгоор хууль бусаар хадгалсан гэх хэрэгт прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн.

Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хэргийн хүлээн авч хянан хэлэлцээд 2023 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/шцт/05 дугаартай шийтгэх тогтоолоор “Гэмт хэрэг үйлдэгдсэний дараа, нэгжлэг, үзлэг, нэр бүхий гэрчүүдийн өгсөн мэдүүлгийн дагуу А, Н нарыг гэмт хэрэгт холбогдуулан сэжигтэн, эсхүл яллагдагчаар татаж шалгах үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон байхад мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу А, Н нарыг сэжигтнээр мэдүүлэг авахын оронд 2022 оны 08 дүгээр сарын 18,19-ны өдөр гэрчээр мэдүүлэг авсан /1хх-91-93, 98-103/, улмаар түүний өөрийнхөө эсрэг өгсөн гэрчийн мэдүүлгийг прокурор нотлох баримтаар тооцож шүүх хуралдаанд гэрчийн мэдүүлгийг үндэслэж гэм буруутайд тооцуулах дүгнэлт нь буруу байна.

Мөрдөгч, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж буй прокурор нь гэмт хэргийн талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг зөвхөн хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр шалгаж тогтоох үүрэгтэй бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлах, хуульд заасан журмыг зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцох боломжгүй юм.

Учир нь мөрдөгч хэн нэгэн хүнийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах үндэслэл бүхий гомдол, мэдээлэл, баримт сэлтийг хүлээн авсан үед тухайн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд

заасан хариуцлага хүлээлгэхийг урьдчилан сануулж, түүнээс гэрчийн мэдүүлэг авах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “... өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно...” гэсэн заалтыг ноцтой зөрчих тул шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд зааснаар тухайн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй.

Өөрөөр хэлбэл, мөрдөгч нь гэмт хэрэгт холбогдуулан шууд нэр заасан, эсхүл хамаарал бүхий нотолгоо бий болсон хүнд худал мэдүүлэг өгвөл хуулийн хариуцлага хүлээлгэхийг сануулж түүнээс өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авах нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй”, мөн хуулийн 31.8 дугаар зүйлийн 1.5. 31.11 дүгээр зүйлийн 1.1-д “Баривчлагдсан сэжигтэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй”, мөн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно.” гэсэн заалтыг тус тус ноцтой зөрчих бөгөөд ийнхүү гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнээс хууль сануулж өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авахыг сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлсэнд тооцно” гэж дүгнэж хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн зүйлчилж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 2 жил 5 сарын хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн.

Уг анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг Давж заалдах шатны шүүхээс хянан хэлэлцээд 2023/ДШМ/309 дугаартай магадлалаар хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Цагаатгасан хэргийн тухайд:

Шүүгдэгч Б.Б нь 2021 оны 6 дугаар сард Беканекс.ком /Becanex.com/ гэх цахим хуудаснаас 1961 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах эмийн тухай конвенцийн 1 дүгээр жагсаалтад багтсан хориглосон, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис болох каннабидолын агууламж бүхий бүтээгдэхүүн “Беканекс СиБиДи” /Becanex CBD oil/ ойл гэсэн бичиглэл бүхий хүрэн өнгийн шилтэй 6 ширхэг зүйл, “Беканекс Си Би Ди ойл” /Becanex CBD oil/ гэсэн бичиглэл бүхий хүрэн бор өнгийн 12 шилтэй шингэн зүйл, “Беканекс Си Би Ди балм” /Becanex CBD balm/ гэсэн бичиглэл бүхий төмөр бөөрөнхий сав бүхий гавар мэт зүйл 3 ширхэг зэргийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас захиалж улмаар Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Улс хоорондын шуудан илгээмжийн газрын Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүсэд 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр I-2723 манифест дугаартай CS731273992DE тодорхойлолттойгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3

хэсгийн 3.3 дах заалтад заасан гэмт хэрэгт прокуророос яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн.

Чингэлтэй дүүгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хэргийг хүлээн авч 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хянан хэлэлцээд 2022/шцт/417 дугаартай шийтгэх тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис нь хүний төв мэдрэлийн системд өвөрмөц нөлөөлөл үзүүлж, улмаар өөрийгөө удирдан жолоодох чадвар муудаж, ураг тархи, төв мэдрэлийн системд хүчтэй давамгайлал үйлчилж, мансууруулах хэмээх сэтгэцийн өвчин үүсгэдэг нөлөөлөл бүхий бодис юм. Уг бодисыг хүн хэрэглэснээр хүн амын эрүүл мэндийг богино хугацаанд өргөн хүрээнд хамран сарниулдаг, хүний биед улиг муу зуршил бий болгодгоороо нийгэмд үзүүлэх хор уршиг өндөртэйд тооцогдон нийгэмд аюултай гэм үйлдэл гэж үздэг. Тиймээс Монгол улсын Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэгт Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэж үзэн хууль тогтоогч хуульчилжээ. Энэ гэмт хэргийг үйлдэж буй хүн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мансуурах зорилгоор шууд санаатайгаар олж авснаар сэдэлт, санаа зорилго нь тодорхойлогдоно.

Гэтэл шүүгдэгч Б.Б нь нэр бүхий 3 төрлийн шингэн болон тосон гоо сайхны бүтээгдэхүүнийг өөрийн нүүр хэсэгт гардаг идээт үрэвсэл болох батгыг эмчлэх зорилгоор нийтэд илэрхий болох цахим сүлжээг ашиглан Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас цахиж Монгол улсад шуудан илгээмжээр нэвтрүүлсэн байна.

Шүүгдэгч Б.Б-ийн улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэн, хэрэглэх байсан гэх шингэн болон тосон гоо сайхны бүтээгдэхүүнүүдийн найрлагат байгаа каннабидолын нь дангаар донтуулах, хамаарал үүсгэж чадахгүй болохыг Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын тодорхойлолтоор /хавтас хэргийн 108 дахь тал/ нотлогдож байна. Мөн уг тодорхойлолт болон эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэр /хавтас хэргийн 102 дахь тал/ шинжээчийн дүгнэлт болон бусад нотлох баримтуудаас үзэхэд уг бүтээгдэхүүний гарал үүсэл, зориулалт, олон улсын хэмжээнд чөлөөтэй худалдаалдаг, тухайн бүтээгдэхүүнүүд нь хориглосон мансууруулах эм, бодисын жагсаалтад багтдаг эсэхийг нарийвчлан тогтоох, бүтээгдэхүүний найрлагад агуулагдах эзлэхүүн, тун ямар хэмжээнд байгаа, нэр бүхий дээрх бүтээгдэхүүнийг ямар хэмжээ тунгаар хэрэглэсэн тохиолдолд хүний бие, сэтгэхүйд мансууруулах нөлөөлөл үзүүлдэг болох, шүүгдэгч уг бодисыг хэрхэн, ямар хэмжээгээр хэрэглэж мансуурч донтох байсан, эсхүл уг бүтээгдэхүүний найрлагад орсон сэтгэцэд нөлөөт бодис гэж үзэж буй каннабидолын агууламжийг найрлагаас салган өөр төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг гарган

авч хэрэглэх боломжтой зэрэг нөхцөл байдлууд нь тогтоогдохгүй байна” гэж дүгнэж шүүгдэгчид холбогдох хэргийг цагаатгаж шийдвэрлэсэн байна.[37]

Дээрх анхан шатны шүүхээр хянан хэлэлцсэн 22 хэргээс давж заалдах шатны шүүхээс шүүгдэгч **О.Т-,** У.А- нар нь бүлэглэн, худалдаалах зорилгогүйгээр хориглосон сэтгэцэд нөлөөлөх бодисыг Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас худалдан авч, Монгол Улсын хилээр нэвтрүүлэн олж авахаар тухайн бодисын төлбөрийг Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын “Vietnam Technological and Commercial Joint Stock Bank” нэртэй банкны 19034719157011 тоот данс руу 875.000 төгрөгийг шилжүүлж, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдөр илгээсэн 781279146772 дугаар ачаанд багтсан “Povidone Iodine 10%” гэсэн бичиглэлтэй цаасан хайрцагтай, 100 мл савлагаатай шингэн, тосорхог Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-ын 2 дугаар жагсаалтад багтсан Эй Ди Би-Бутаника (ADB BUTANICA)-ын агууламжтай нийт 100.8234 грамм цэвэр жинтэй хориглосон сэтгэцэд нөлөөлөх бодисыг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын харьяа Ди Эйч Эл (DHL) дэх гаалийн хяналтын бүсэд хүлээн авч улсын хилээр нэвтрүүлсэн гэх хэргийг Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2024/ШЦТ/813 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай тооцож, 5-6 жил 8 сарын хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэснийг шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч нараас гаргасан гомдлоор хянан хэлэлцээд цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Дээрх хэргийг Давж заалдах шатны шүүх 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 2025/шцт/132 дугаартай тогтоолд “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлд заасан хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-ын 2 дугаар жагсаалтад нэрлэн заасан бөгөөд энэ хэргийн тухайд “Эй Ди Би Бутаника” /ADB-BUTANICA/ гэх бодисыг Мансууруулах эмийн асуудал эрхэлсэн комисс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 5 дугаар хуралдаанаар хориглосон сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтад оруулж, 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр бүх оролцогч улсуудад мэдэгдсэнээр 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр тус конвенц хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ.

Өөрөөр хэлбэл “Эй Ди Би Бутаника” /ADB-BUTANICA/ гэх бодисыг тус конвенцид нэрлэн зааж оруулснаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжид хамаарах болжээ.

[37] https://shuukh.mn/single_case/75376

Гэтэл шүүгдэгч О.Т-, У.А-, О.Э- нарын холбогдсон гэмт хэрэг нь цаг хугацааны хувьд 2023 оны 7 дугаар сарын 24, 28-ны өдрүүдэд үйлдэгдсэн буюу прокуророос О.Т-, У.А- нарыг бүлэглэн худалдаалах зорилгогүйгээр хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдөр улсын хилээр нэвтрүүлсэн, О.Т-, О.Э- нарыг бүлэглэн худалдаалах зорилгогүйгээр хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдөр улсын хилээр нэвтрүүлсэн гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан, яллах дүгнэлт үйлдсэнийг цаг хугацааны хувьд авч үзвэл тухайн бодис нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинж болохоос өмнө үйлдэгджээ.

Иймд дээр дурдсан үндэслэлээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр О.Т-, У.А-, О.Э- нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, тэдгээрийг цагаатгаж, хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж, шүүгдэгч болон тэдгээрийн өмгөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлуудыг хүлээн авч шийдвэрлэлээ.

О.Т-, У.А-, О.Э- нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, тэдгээрт Монгол улсын хилээр гарахыг болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарласан хязгаарлалт тогтоосон таслан сэргийлэх арга хэмжээ авч, О.Т-, У.А-, О.Э- нарыг нэн даруй суллах нь зүйтэй байна” гэж дүгнэж шүүгдэгч нарт холбогдох хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.[38]

Арав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал

Арван нэг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс хүүхэд, өсвөр үеийг хамгаалах арга зам, шийдэл

[38] https://shuukh.mn/single_case/21453

ДҮГНЭЛТ

Судалгааны ажилд үндэслэн дараах дүгнэлтийг дэвшүүллээ. Үүнд:

1. Улсын хэмжээнд сүүлийн 7 жилд нийт 219,410 гэмт хэрэг бүртгэгдсэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 1539 буюу 0.7 хувийг эзэлж байна. Тус гэмт хэрэг нь хүний эрүүл мэнд, хүн амын удмын сан, эдийн засгийн бие даасан байдал, соёл иргэншил оршин тогтнох, язгуур ашиг сонирхлыг хөндсөн үндэсний аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад үр дагавар, хор уршиг нь их байдаг.

2. Тус гэмт хэрэгт оноож байгаа манай улсын ялын бодлого бусад орнуудтай харьцуулахад харьцангуй хөнгөн, шүүхээс оноож байгаа ялын хэмжээ ихэвчлэн 1 жилийн хугацаатай хорих ял, зорчих эрхийг хязгаарлах, албадлагын арга хэмжээ авч шийтгэж байгаа нь гэмт хэрэг гаралтад нөлөөлж байна гэж дүгнэж байна.

3. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад сэтгэцэд нөлөөт метамфетамин агууламжтай “мөс” гэх бодисын урсгал, нийлүүлэлт 2019 оныг хүртэл Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас нийлүүлэгдэж байсан бол 2019 оноос хойш буюу коронавируст халдварын цар тахал бүртгэгдэж, БНХАУ-ын хил хаагдсан үеэс Бүгд Найрамдах Турк Улсаас синтетик төрлийн мансууруулах бодисын 75.8 хувийг хууль бусаар хил нэвтрүүлсэн гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дэлхий хар зах зээл буюу Darkweb сайтаас цахимаар худалдан авч, синтетик төрлийн мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, цахим тоглоом, криптовалют ашиглан төлбөр тооцоо хийх, хууль бусаар олсон орлогын эх үүсвэрийг нуун далдлах зэрэг үйлдлийн аргуудыг ашиглаж байгаа нь илрүүлэхэд хүндрэл учруулж байна.

5. НҮБ-ын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх албаны гаргасан 2021 оны тайланд дурдсанаар 2030 он хүртэл орлогын түвшин бага, хөгжил буурай болон хөгжиж буй улс орнуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч 43 хувиар, дундаж орлоготой улсуудад 10 хувиар тус тус өснө гэж дүгнэсэн.

Тус судалгаагаар 2030 он гэхэд манай улсын хэмжээнд одоо бүртгэгдсэн байгаа 4168 хэрэглэгчийн тоо 40 хувиар буюу 5835, мөн үүнийг дагасан далд хэрэглэгчдийн тоо 30,000-100,000 орчим болж нэмэгдэх магадлалтай байна.

Санал

1. Монгол Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч, донтогч, далд хэрэглэгчдийн талаарх тандалт судалгааг улсын хэмжээнд нарийвчлан гаргах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, дотоодын нөхцөл байдлыг бодитоор тодорхойлж, дүн шинжилгээнд суурилсан гэмт хэрэгтэй тэмцэх ажил арга хэмжээг хэрэгжүүлэх,

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт тархан ургасан олсны ургамлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, газар тариалан эрхлэгч нартай хамтран Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйл (Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг)-д газар тариалан эрхлэгчид өөрсдийн эзэмшил, ашиглалд байгаа газар болон газрын ойр орчмын 1000-2000 метр зайд ургаж байгаа хог (каннабис) ургамлыг устгаж байх заалтыг нэмэлтээр оруулах,

3. Мансуурах зөрчилд холбогдсон, донтох эмгэгтэй хүнийг нийгмээс тусгаарлаж албадан эмчилгээнд хамруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, олон улсын чиг хандлагад нийцүүлсэн “Дэмжих төв”-ийг Эрүүл мэндийн яамны дэргэд байгуулах,

4. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-д зааснаар баривчлах, 100 нэгжээр торгох, албадан сургалтад хамруулах шийтгэл оногдуулж байгаа нь хангалтгүй байгаа тул дахин зөрчил үйлдэх шалтгаан болж байна.

Иймд дээрх оногдуулж буй шийтгэл дээр нэмэлтээр мансууруулах бодис хэрэглэн давтан мансуурсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг давтан хэрэглэсэн үед хүний галт зэвсэг эзэмших, тээврийн хэрэгсэл жолоодох, төрийн албанд ажиллах, цэргийн алба хаах, улсаас халамж, тэтгэмж авах, гадаад, дотоодын сургалтын тэтгэлэгт хамрагдах болон багшлах, эмчлэх зэрэг тусгай мэргэжлийн ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг хязгаарлах,

Хэрэг бүртгэлтийн шатанд сэжигтэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авдаг болох буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дэх хэсгийн 1.1 хувийн баталгаа авах, 1.3 хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөгч бие даан авах хуулийн зохицуулалтыг тус хуулийн төсөлд тусгах нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.

Дүгнэлт

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт тэр дундаа улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдэл, бодисын төрөл зүйлээс харахад 2019 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үе буюу 2019 оноос өмнөх болон дараах гэж ангилж болохоор байна. Цар тахлаас өмнө улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийн арга, хэлбэр нь олон улсад зорчигч иргэд биедээ болон дагалдах ачаандаа бусад бараа бүтээгдэхүүнийг нуувч болгох хэлбэрээр үйлддэг байсан бол цар тахлын үед дэлхийн улс орнууд хилээ хааж гадаадын иргэн хүлээж авахгүй болсны улмаас гадаадад зорчих боломжгүй болсон цаг үед улс хоорондын шуудан илгээмжийг ашиглах хэлбэр илүү давамгайлж эхэлсэн байна.

Цахим худалдаа хөгжихийн хэрээр олон улсын шуудангийн үйлчилгээ мөн дагаж хөгжиж байгаа нь далайд гарцгүй, жижиг зах зээлтэй манай улсын иргэдэд хүссэн бараа бүтээгдэхүүнийг бага өртгөөр өөрийн гар дээр авах боломж бүрдэж байгаа хэдий ч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчид үүнийг гэмт хэрэг үйлдэх арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь хууль хяналтын байгууллагуудад томоохон хүндрэл учруулж байна.

Улсын хилээр нэвтрүүлэх арга хэлбэр нь гадаад улс оронд зорчиж буй иргэдэд дайвар ачаа хэлбэрээр өгч явуулаад тухайн иргэн хууль хяналтын байгууллагад саатуулагдаж гэмт хэргийн хохирогч болдог байдал одоо ч гарсаар байгаа ба олон улсын шуудан илгээмжээр захиалга хийхдээ бусдын хувийн мэдээлэл, бичиг баримтыг ашиглаж тухайн этгээдийн нэр дээр захиалга хийж гэмт хэргийн хохирогч болгох байдал нэмэгдэж байгаа тул энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх мэдээллийг нийтэд тогтмол түгээж иргэдийг мэдээ мэдээллээр хангах нь зүйтэй байна.

Дүгнэлт, санал

Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, донтолт, нас баралт болон энэ төрлийн гэмт хэргийн нийгэм дэх мэдлэгийг үнэлсэн үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг дэвшүүлж байна. Тодруулбал:

1. Монгол Улсад үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт МЕТ (метамфетамин) болон ТНС (тетрагидроканнабинол) зэрэг нь хурдан хугацаанд донтуулж, хамаарал үүсгэдэг бодис учир түгээмэл хэрэглэгдэж энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна.

2. Сүүлийн жилүүдэд мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын улмаас донтсон, нас барсан иргэдийн тоо тогтмол нэмэгдэж байна.

3. Их дээд сургуулиудын оюутнуудаас авсан судалгаагаар 39.6% нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн бөгөөд тэдний дийлэнх нь нийгмийн дунджаас дээш орлоготой өрхийн гишүүд байна.

4. Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодсонд донтогсод өвчний олон улсын 10 дугаар ангиллын F11-F19 гэсэн оношгой бөгөөд тэдгээрийн дийлэнх нь F19 буюу “Олон төрлийн сэтгэц идэвхт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан төрхийн эмгэгүүд” оношгой эмчлэгдэж байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын ангилал, төрлийг тогтоох шинжилгээг улам боловсронгуй болгох.

2. МЕТ (метамфетамин) болон ТНС (тетрагидроканнабинол) төрлийн бодисын хэрэглээ, тухайн төрлийн бодисыг хэрэглэсний улмаас үүсэх донтолтыг эмчлэх арга зүйг нэвтрүүлэх.

3. Их дээд сургуулиудын оюутан, залуучуудын дунд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах.

4. Хууль зүй, Анагаах ухаан, Нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйг боловсруулах.

Дүгнэлт

Өсвөр насныхныг хар тамхи, мансууруулах бодисын аюулд өртөхөөс сэргийлэх нь зөвхөн нэг байгууллага бус, гэр бүл, сургууль, олон нийт, төрийн болон ТББ-уудын хамтын ажиллагаа шаардсан цогц асуудал юм. Тиймээс урт хугацааны тогтвортой бодлого, боловсрол, олон нийтийн оролцоог хослуулсан нэгдмэл арга барил хэрэгтэй байна. Өсвөр нас бол хүний амьдралын хамгийн эмзэг, сэтгэлзүйн хувьд хүнд үе юм. Энэ үед хүүхэд, өсвөр насныхныг хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээнд татагдах эрсдэл өндөр байдаг.

Орчин үеийн нийгэмд мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэж байгаа нь залуучуудын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, улс орныхоо ирээдүйд гүн гүнзгий сөрөг үр дагаврыг авчирдаг. Тиймээс өсвөр насныхныг хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь зөвхөн нийгмийн үүрэг биш, бүхий л салбарын хамтын ажиллагааны асуудал болтлоо хөгжих шаардлагатай байна.

Санал

Сургуулийн боловсролыг чангатгах:

Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, түүний хор уршгийн талаар сурагчдад мэдээлэл өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хичээл, сургалтыг сургууль бүрд тогтмол зохион байгуулах хэрэгтэй. Өсвөр насныхны сэтгэл зүй, бие махбодын онцлогт тохирсон хичээлийн агуулга боловсруулах нь чухал юм.

Гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх:

Эцэг эхчүүдийн боловсрол, сэтгэлзүйн дэмжлэг нь хүүхдийн хэрэглээнээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Эцэг эхийн хяналт, анхаарал, харилцаа нь хүүхдийг зөв сонголт хийхэд нөлөөлөх гол хүчин зүйл болдог.

Олон нийтийн санаачилга, сурталчилгааг нэмэгдүүлэх:

Хэвлэл мэдээлэл, цахим орчин, сошиал медиа зэрэгт хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээний эрсдэлийг таниулах, иргэдийн дунд ойлголт өгөх сургалт, уриалга үр дүнтэй болохыг судалгаа харуулж байна. Үүний хүрээнд олон нийтийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь үр дүнтэй арга барил болно.

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа:

Хууль сахиулах, боловсролын байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, тэдний гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой болох нь урьдчилан сэргийлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл юм.

Психологийн дэмжлэгийг сайжруулах:

Өсвөр насныхны сэтгэл зүй, эрүүл мэндийг хамгаалах, сэтгэлзүйн асуудал, стресс, ганцаардалтай тэмцэхэд нь туслах психологийн зөвлөгөө, эмчилгээний үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гадаад туршлага, төсөл хэрэгжүүлэлтийг судлах:

Тухайлбал, Исланд улс өсвөр насныхны мансууруулах бодисын хэрэглээг бууруулахад амжилттай ажилласан бөгөөд тэдний туршлагаас суралцаж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч болох юм. Энэ мэт олон улсын туршлагаас суралцах нь бодит үр дүнд хүргэхэд чухал үүрэгтэй.

Энэхүү зөвлөмжүүд нь өсвөр насны хүүхдүүдийг хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай цогц арга хэмжээг хамарсан бөгөөд нийгмийн бүх талын оролцоо, хамтын ажиллагаа хэрэгтэй гэдгийг онцолж байна. Энэ нь зөвхөн урьдчилан сэргийлэх ажил төдийгүй, мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэх стратегийн нэг хэсэг байж чадах юм.

Дүгнэлт ба санал

Хар тамхи хэрэглэх зан үйлийн сэтгэл зүйн үндсийг онолын түвшинд авч үзэх нь донтолт хэмээх эмгэг хамаарлыг олон талаас нь ойлгоход чухал ач холбогдолтой юм. Өвчний загвар онол донтолтыг биологийн хамааралтай холбож, зан үйлийн онолууд тухайн зан үйлийн нөхцөлдүүлэлт, давталт, шагналын тогтолцоог онцолдог. Мөн импульсийн хяналт, сэтгэл зүйн хамгаалалт, нийгмийн дуурайлтаас үүдсэн зан үйл нь тухайн хувь хүнийг донтох зан үйлийн орчинд илүү өртөмтгий болгодог болох нь харагдаж байна.

Манай орны хувьд хар тамхины хэрэглээний эрсдэлт хүчин зүйлс улам бүр нэмэгдэж байгаа нь энэ асуудлыг зөвхөн хууль, хяналтын байгууллагаар бус сэтгэл зүй, боловсрол, нийгмийн хамгааллын түвшинд цогцоор нь авч үзэх шаардлагатайг харуулж байна. Судалгаагүй, онолын шинж чанартай энэхүү өгүүлэл нь дараах зөвлөмжүүдийг дэвшүүлж байна:

1. Сэтгэл зүйн урьдчилан сэргийлэх ажлуудыг нэмэгдүүлж, өсвөр үе болон залуусын дунд хар тамхины хор уршгийн талаарх сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг тогтмолжуулах;

2. Донтох зан үйлд өртөх магадлалтай эмзэг бүлгийг тодорхойлох сэтгэл зүйн оношилгоо, боловсруулж нэвтрүүлэх;

3. Гэр бүлийн болон хамт олны сэтгэл зүйн орчныг бэхжүүлэх замаар орчны нөлөөллийг бууруулах;

4. Хар тамхи хэрэглэгчидтэй ажиллах сэтгэл зүйчдийн мэргэшил, аргачлалыг сайжруулж, сэтгэл зүйн зөвлөгөө, бүлгийн дэмжлэгийг тулгуурласан сэргийлэх, сэргээн засах хөтөлбөр хэрэгжүүлэх;

5. Судалгаанд суурилсан бодлого боловсруулахад онолын суурь судалгаануудыг тогтмол явуулах шаардлагатай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. World Health Organization. (2022). World Drug Report 2022. Geneva: WHO.

2. UNODC. (2021). Preventing Drug Use Among Youth: Evidence-Based Interventions. Vienna: United Nations Office on Drugs and Crime.

3. Brook, J.S., Morojele, N.K., Pahl, K. & Brook, D.W. (2020). Predictors of Drug Use Among Adolescents: The Role of Parent-Child Relationships. Journal of Adolescent Health, 66(1), 7–14.

4. National Institute on Drug Abuse. (2023). Teens and Drugs: Trends and Prevention Strategies. Bethesda, MD.

5. Цагдаагийн ерөнхий газар. (2024). Монгол Улсад хар тамхины гэмт хэрэгт өсвөр үеийнхэн холбогдсон тохиолдлын тойм мэдээлэл. Уб., 2024

1. Засгийн газрын 2000 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр

2. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

3. Монгол Улсын Их Хурлын2020 оны 52 дугаар тогтоол. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого". 2020.

4. Исаев, Игорь. В поисках забвения. Всемирная история наркотиков 1500—2000. — М.: ЭТП, 2003. — ISBN 5-9410-6029-7

5. Мөнхболд, Ж. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа - 2. Уб., 2013. 3 дахь тал.

6. Болдбаатар, Ж. Хар тамхи мансууруулах бодистой холбогдсон гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн шинж. Уб., 2001.4 дэх тал.

7. “Online World Drug Report 2024 - Drug market patterns and trends.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/wdr2024-drug-market-trends.html

8. “Narcotic Drugs.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://www.incb.org/incb/en/narcotic-drugs/index.html

9. “Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://legalinfo.mn/mn/detail?lawId=206781

10. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://legalinfo.mn/mn/detail?lawId=315

11. “Эрүүгийн тухай хууль.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://legalinfo.mn/mn/detail?lawId=315

12. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр.” Accessed: Apr. 05, 2025. [Online]. Available: https://legalinfo.mn/mn/detail/12557

13. “Гэмт хэрэг.” Accessed: Apr. 02, 2025. [Online]. Available: https://police.gov.mn/a/7418

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
3. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны тайлан
https://www.unodc.org/unodc/en/drug-trafficking/central-asia.html
https://www.wcoasiapacific.org/about-us
4. Гаалийн байгууллагын Кайс программын зөрчлийн мэдээллийн санд бүртгэгдсэн зөрчлийн мэдээлэл
https://cais.ecustoms.mn/CAIS/normal.do?_common_serviceName=retrieveCriminalPageList&_common_view=jsp/rms/sof/SOffenseCriminalList.jsp

Хууль эрх зүйн баримт бичиг: Монгол Улсын Их Хурал. (2017). *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*.
Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №23.
Хууль эрх зүйн баримт бичиг: Монгол Улсын Их Хурал. (2017). *Эрүүгийн хууль*. Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №23.
Тайлан: ЦЕГ, Гэмт хэргийн статистик тайлан 2013-2024 он.
Тайлан: НҮБ-ын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх хорооноос гаргасан Дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын 2023, 2024 оны тайлан.
Цахим сайт: НҮБ-ын Хар тамхи гэмт хэрэгтэй тэмцэх албаны албан ёсны цахим хуудас, https://wdr.unodc.org
Тайлан: НҮБ-ын Дэлхийн мансууруулах бодисын нөхцөл байдлын тайлан. 2024. Хоёрдугаар номын 39-р хуудас. Тайлан: НҮБ-ын Хар тамхитай тэмцэх албаны “Улс орнуудын гэмт хэргийн хөдөлгөөний мэдээлэл” 2024 он